

**ОЛОН УЛСЫН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ УС, НАМГАРХАГ ГАЗАР, ЯЛАНГУЯА
УСНЫ ШУВУУД ОЛНООР АМЬДАРДАГ ОРЧНЫ ТУХАЙ БУЮУ РАМСАРЫН
КОНВЕНЦИЙН ТАЙЛАН**

Санхүүжүүлсэн

**Нэгдсэн үндэстний
байгууллагын хөгжлийн
хөтөлбөр**



**Дэлхийн байгаль
хамгаалах сан**



**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Гүйцэтгэсэн

**Монголын шувуу
судлалын
нийгэмлэг**



**Монгол улсын их
сургууль**




Хамтран ажилласан

**Рамсарын конвенцийн
Үндэсний зөвлөл
Тусгай хамгаалалттай
нутгийн удирдлагын газар**



**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

**ШУА-ийн
Биологийн хүрээлэн**



**Зэрлэг амьтан
судлах, хамгаалах
төв**



Тайланг нэгтгэн бичсэн:

С. Гомбобаатар

**Рамсарын конвенцийн Үндэсний зөвлөл
Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсэг
Монгол улсын их сургуулийн Биологи, биотехнологийн сургууль,
Шувуу судлалын лаборатори**

Монголын шувуу судлалын нийгэмлэг
Улаанбаатар хот шуудангийн 46А салбар,
хайрцаг 537.
Email: gomboo@num.edu.mn; info@mos.mn

Агуулга

ӨМНӨХ ҮГ

РАМСАРЫН КОНВЕНЦИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Рамсарын конвенцийн үүрэг
Конвенцийн үндсэн бүрэлдэхүүн
Конвенцид нэгдэн орсон талууд
Конвенцийн байнгын хороо
Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсэг
Нарийн бичгийн дарга нарын газар

МОНГОЛ УЛС БА РАМСАР

КОНВЕНЦИД НЭГДЭХЭЭС ӨМНӨХ УС НАМГАРХАГ ГАЗРУУДЫН СУДАЛГАА, ХАМГААЛЛЫН АЖЛЫН ТОЙМ

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРСНООС ХОЙШХИ УС НАМГАРХАГ ГАЗРУУДЫН СУДАЛГАА, ХАМГААЛЛЫН АЖЛЫН ТОЙМ

ОЛОН УЛСЫН ХУВЬД АЧ ХОЛБОГДОЛТОЙ РАМСАРЫН ЖАГСААЛТАД БҮРТГЭЛТЭЙ ГАЗАР НУТГУУД

Монгол Дагуур (1997)
Нууруудын хөндийн нуурууд (Бөөн цагаан, Таацын цагаан, Адгийн цагаан,
Орог нуур) (1998)
Өгий нуур (1998)
Тэрхийн цагаан нуур (1998)
Айраг нуур (1999)
Хар-Ус нуур (1999)
Ачит нуур, түүний орчмын ус намгархаг газар (2004)
Буйр нуур, түүний орчмын ус намгархаг газар (2004)
Ганга нуур, түүний орчмын ус намгархаг газар (2004)
Увс нуур, түүний орчмын ус намгархаг газар (2004)
Хурх, Хүйтэн голын хөндийн нуурууд (2004)

РАМСАРТ БҮРТГЭЛТЭЙ УС НАМГАРХАГ ГАЗАР НУТГИЙН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН БУСАД АЖИЛ

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРСОН ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДЫН БАГА ХУРЛУУДААС ГАРСАН ШИЙДВЭРҮҮД БА ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ МОНГОЛ ОРОНД

РАМСАРЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН СТРАТЕГИ, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: 2010-2013

КОНВЕНЦИЙН ТАЛУУДЫН БАГА ХУРАЛ БА ШИЙДВЭРҮҮД

КОНВЕНЦИЙН ТАЛУУДЫН 7-Р ХУРАЛ- “Хүмүүс ба ус намгархаг газар: амин чухал холбоо” уриа

КОНВЕНЦИЙН ТАЛУУДЫН 8-Р ХУРАЛ- “Ус намгархаг газар: ус, амьдрал ба соёл” уриа

КОНВЕНЦИЙН ТАЛУУДЫН 9-Р ХУРАЛ- “Ус намгархаг газар ба ус: амьдралыг тэтгэгч ба амьжиргаа” уриа

КОНВЕНЦИЙН ТАЛУУДЫН 10-Р ХУРАЛ- “Эрүүл ус намгархаг газар ба эрүүл хүн” уриа

ШИЙДВЭРҮҮДИЙН БИЕЛЭЛИЙГ ХАНГАХАД ТОХИОЛДОЖ БУЙ БЭРХШЭЭЛ, АМЖИЛТ СУРГАМЖ

САНАЛ

ИШ ТАТСАН БҮТЭЭЛ

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Рамсарын конвенцийн хүрээнд Ус намгархаг газар, усны шувуудын чиглэлээр мэдээлэл, мэдээ, баримт солилцох, хамтран ажиллахад шаардлагатай хүмүүсийн нэр, хаяг

Өмнөх үг

Монгол улс 1992 онд баталсан Үндсэн хуулиараа Монгол улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан байдаг. Хүний эрүүл, аюулгүй орчныг хангах ажлын хүрээнд төрөөс байгаль орчныг хамгаалах талаар бодлого, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлж ирсэний зэрэгцээ дэлхийн улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, шинэлэг нээлт, нэгдсэн шийдвэртэй хөл нийлүүлэн хөгжих зорилт тавьж олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөж батлагдсан байгаль орчны гэрээ, конвенциудыг соёрхон баталж, нэгдэж ороод байна. Эдгээр конвенцийн нэг нь “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц”, эсвэл товчоор “Рамсарын конвенц” хэмээн нэрлэгдэх олон улсын гэрээ юм.

Ус, намгархаг газар гэдэгт байгалийн ба хиймэл, байнгын ба түр зуурын, урсгал ба тогтмол, цэнгэг ба шорвог ус, намаг, балчиг, хүлэр намаг бүхий газрууд болон далайн татлагынхаа үеэр 6 метрээс илүүгүй гүнтэй далайн эргийн ус бүхий газрыг багтаах бөгөөд энэхүү конвенцийн хамрах хүрээ нь бүс нутаг, улс орны хилээр үл хязгаарлагдана.

Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцийг 1971 онд Ираны Рамсар хотод байгуулсан бөгөөд энэхүү конвенцийн үндсэн зорилго нь олон улсын хэмжээнд ач холбогдол бүхий ус намгархаг газрыг хамтран хамгаалах, зохистой ашиглах, тухайн орчны биологийн олон янз байдлыг ялангуяа ус намгархаг орчноос хараат амьдралтай зүйлсийг хамгаалах үйл ажиллагааг олон улсын хэмжээнд эрхлэн гүйцэтгэх зорилготой.

Энэхүү конвенцид 2012 оны байдлаар 160 улс орон нэгдэн орсон бөгөөд 193 сая га газрыг хамарсан 2005 газар нутгийг олон улсын ач холбогдол бүхий хэмээн бүртгэн авчээ.

Монгол улс энэхүү конвенцид 1998 оны 4 сарын 8-нд албан ёсоор нэгдэн орсон бөгөөд конвенцийн үйл ажиллагаанд тогтмол оролцож ирсэн байна. “Рамсарын жагсаалт”-д манай орны 11 газар - (Өгий нуур (1998 он), Монгол Дагуур (1997), Тэрхийн Цагаан нуур (1998), Нууруудын хөндийн нуурууд (1998), Хар-Ус нуур (1999), Айраг нуур (1999), Ачит нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Ганга нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Увс нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Хурх, Хүйтэн голын хөндийн нуурууд (2004)) бүртгэлтэй.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ус, чийг намгархаг газрын хатах, ширгэх явц эрчимжиж буй нь энэ асуудлыг хариуцсан төрийн байгууллага төдийгүй хувь хүн бүрийн анхаарлыг ихээр татах боллоо. Манай улсад ус, чийг намгархаг газрын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон байгууллага, хувь хүмүүс байдаг ч тэдгээрийн үйл ажиллагаа нь хэт саланги тусдаа буюу “бие даан хувиа хичээсэн шинжтэй” байна. Нөгөө талаас, ихэнх судалгаа, хамгаалал, бодлогын баримт бичиг нь усны физик, химийн шинжийг тодорхойлох, ус ашиглалт, төлбөрийн асуудлыг хөндсөн ба харин усны чанарын индикатор болсон биологийн зүйлүүд тухайлбал усны шувууд, тэр дотроо усны ургамал, амьтдаар хооллодог шувууд гэх нэгэн томоохон бүрэлдэхүүний талаарх судалгаа шинжилгээний ажил тэр бүр бүрэн дүүрэн хийгдээгүй байна.

Олон улсын хувьд ач холбогдолтой хүн, усны шувуудын амьдрах орчин болсон ус, намгархаг газрын судалгаа, хамгааллыг энэхүү конвенцид орохоос өмнө болон орсны дараах байдлаар үнэлэхийн тулд “Рамсарын жагсаалт”-д бүртгэгдсэн газар нутгуудад

гүйцэтгэсэн судалгаа, хамгаалал, түүний бодлогын чиглэлтэй ажлуудыг нэгтгэх нь бидний ажлын үндсэн зорилго байлаа. Иймээс ч энэ конвенцид орсон ус, ус намгархаг газрын өнгөрсөн болон өнөөгийн төлөв байдлын талаар цуглуулсан материалын хүрээнд боловсруулалт хийж та бүхэнд хүргэж байна.

Ус, ус чийг намгархаг газрын судалгаа, хамгааллын ажил, ашиглал, хамгааллын бодлогыг өнгөрсөн- одоо- ирээдүй гэсэн гурван үед үнэлэхэд бидний нэгтгэн боловсруулсан материал хангалтгүй учир нэгдсэн дүгнэлт гаргахаас татгалзлаа. Бидний энэхүү ажил нь ус болон ус намгархаг газрын тухай ажил, асуудлуудыг нэгтгэн боловсруулах, үнэлэлт, дүгнэлт өгөх ирээдүйн ажлуудад чухал суурь баримт, материал болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Ус болон ус чийг намгархаг газрын талаарх ажлын үнэлэлт, дүгнэлт нь бидний хамтын ажиллагааны үр дүнд л бүрэн дүүрэн гарах тул энэ ажилд ороогүй орхигдсон таны судалгаа, хамгааллын ажил байвал Конвенцийн Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсгийн Үндэсний төлөөлөгч доктор С.Гомбобаатарт хандаж, хамтран ажиллахыг хичээнгүйлэн хүсэж байна.

Д. Батболд
БОАЖЯ-ны Гадаад хамтын ажиллагааны
хэлтсийн дарга, Рамсарын конвенцийн Үндэсний зөвлөлийн дарга
E-mail: dbatbold@mne.gov.mn

Доктор С. Гомбобаатар
Рамсарын конвенцийн Шинжлэх ухаан, техникийн
хяналтын ажлын хэсгийн үндэсний төлөөлөгч
Монгол улсын их сургуулийн
Биологи, биотехнологийн сургууль,
Шувуу судлалын лаборатори
Улаанбаатар хот шуудангийн 46А салбар, хайрцаг 537.
E-mail: gomboo@num.edu.mn; info@mos.mn

РАМСАРЫН КОНВЕНЦИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Энэ конвенцийг “Олон улсын хувьд ач холбогдолтой ус намгархаг газрын конвенц”, “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц”, “Рамсарын конвенц” гэх зэргээр нэрлэдэг. Энэ конвенц нь ус намгархаг газар, түүний нөөцийг зохистой ашиглах, хамгаалахад улс орон бүрийн үйл ажиллагаа, мөн олон улсын хамтын ажиллагааг чиглүүлэх зорилго бүхий Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр юм.

Нүүдлийн шувуудын амьдрах орчин болсон ус намгархаг газрын доройтол, тэдгээрийн хаталт ширгэлт ихэссэнээс 1960-аад оны үеэс Засгийн газрын болон төрийн бус байгууллагууд хамтран хэлэлцэж, улмаар 1971 онд Ираны Рамсар хотноо хуралдаж гэрээ хэлэлцээр болгон соёрхон баталж, харин хожуу буюу 1975 онд гэрээ хэлэлцээрийг албан ёсны болгон, хамтрагч талууд гарын үсэг зуржээ.

Рамсарын конвенц нь эх газар, бүс нутгийн бүхий л хүрээг хамарсан, олон улс орныг өөртөө багтаасан хүрээлэн буй орчин, ялангуяа тухайлсан нэгэн экосистемийн талаарх олон улсын гэрээ хэлэлцээр болно. Энэ конвенцийн эрхэм зорилго бол орон нутаг, бүс нутаг, үндэсний болон олон улсын хамтын үйл ажиллагаагаар бүхий л ус намгархаг газрыг дэлхийн тогтвортой хөгжлийн төлөө зохистой ашиглах, хамгаалахад оршино.

Энэхүү конвенц нь ус намгархаг газар гэдэгт ус намгархаг газрын нэн олон янз байдлыг ойлгодог бөгөөд тухайлбал нуур, гол, цөөрөм, гол болон нуурын хөндийн татам, намагжсан газар, чийглэг тал хээр, хүлэрт намаг, баян бүрд, голын адаг, цутгал, нуур болон тэнгисийн түрлэгээр үүссэн чийглэг, эсвэл шаварлаг хэсэг, тэнгисийн эрэг орчмын чийглэг хэсэг, чийглэг ихтэй мангро ой, шүрэн хад, хүний гараар бүтсэн загас үржүүлэх цөөрөм, цагаан будааны талбай, давсархаг болон бусад усан сан зэргийг багтаан ойлгоно.



Сангийн далай нуур орчмын ус намгархаг газар

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Энэ конвенцид 2011 оны байдлаар 160 улс орон нэгдэн орсон бөгөөд 193 сая га газрыг хамарсан 2,005 газар нутгийг олон улсын ач холбогдол бүхий хэмээн бүртгэн авчээ. Конвенцийн хэрэгжилтийг хангах, дэмжих үүднээс Талуудын Бага хурлыг зохион байгуулж, 3 хүртэл жилийн хугацаанд ээлжит хуралдааныг зарлан хуралдуулж, дараагийн хуралдаан болох газар ба хугацааг товлodoг. Одоогоор нийт 10 удаагийн хуралдааныг зохион байгуулсанаас хамгийн сүүлд БНСУ-ын Чангвон хотод Хэлэлцэн тохирогч Талуудын Бага хурлын 10-р хуралдааныг “Эрүүл ус, чийг бүхий намгархаг газар ба эрүүл хүн” уриан дор 2008 оны 10 сарын 28-наас 11 сарын 04-нд болж, хүний сайн сайхан байдал ба ус, чийг бүхий намгархаг газрын тухай “Чангвоны тунхаглал”-ыг гаргав. Энэ хурлаар Талуудын Бага хурлын 11-р хуралдааныг Румын улсын Бухарест хотод хийхээр тогтжээ.

Ус намгархаг газрыг өргөнөөр ашиглах гэж юу вэ? Ус намгархаг газрыг өргөнөөр ашиглах гэдэгт ”Тогтвортой хөгжлийн хүрээнд экосистемийн олон чиглэлт арга замыг хэрэгжүүлэх аргаар ус намгархаг газрын экологийн үндсэн шинжийг хадгалах, хамгаалахыг” ойлгоно. Иймээс өргөнөөр ашиглах гэдэг нь ус намгархаг газар, түүний нөөцийг хүнд хүртээмжтэй, тогтвортой ашиглах, хамгаалахыг хэлнэ.

Рамсарын конвенцийн үүрэг

Рамсарын Конвенцид нэгдсэн талууд, эсвэл гишүүн улс орнууд нь энэхүү конвенцийн дараах үндсэн “Гурван тулгуурыг” хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг юм. Үүнд:

- Олон улсын хувьд ач холбогдолтой ус намгархаг газрын жагсаалтыг гаргаж, албан ёсоор бүртгэх ба үр нөлөө бүхий менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх,
- Газар ашиглах Үндэсний төлөвлөгөө, бодлого, хууль эрх зүй, менежментийн үйл ажиллагаа, нийтийн боловсролын тусламжтайгаар бүхий л төрлийн ус намгархаг газрыг зөв зохистой ашиглаж буй эсэхэд анхаарлаа хандуулах,
- Хил дамжсан болон хамтран эзэмшдэг ус намгархаг газар, түүнд амьдрах зүйл, мөн тухайн ус намгархаг газарт сөргөөр нөлөөлж болохуйц дэд бүтэц, бусад хөгжлийн төслүүдэд анхаарлаа хандуулан олон улсын төвшинд хамтран ажиллах зэрэг болно.

Конвенцийн үндсэн бүрэлдэхүүн

Конвенцийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Конвенцид нэгдэн орсон Хэлэлцэн тохирогч Талууд, Байнгын хороо, Нарийн бичгийн дарга нарын газар голлон оролцдог төдийгүй конвенцид туслах, мэргэжлийн зөвлөгөө өгөх үүрэгтэй Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсэг, Олон улсын хамтран ажиллагч байгууллагууд идэвхтэй оролцоно. Конвенцид нэгдэн орсон Хэлэлцэн тохирогч талууд гурван жил тутам хуралдаж, энэхүү конвенцийн бодлогын баримт бичгүүд болох тогтоол, шийдвэр, саналыг хэлэлцэн гаргадаг уламжлалтай. Конвенцийн үйл ажиллагаа нь энэхүү конвенцийн ажлын төлөвлөгөөтэй уялдсан стратегийн төлөвлөгөөг Конвенцид нэгдэн орсон Хэлэлцэн тохирогч талууд, Байнгын хороо, Нарийн бичгийн дарга нарын газар, Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсэг, Олон улсын хамтран ажиллагч байгууллагуудын санал, зөвлөгөөнд үндэслэн батлан гаргаж, улмаар мөрдөн ажиллах зарчимд тулгуурлана. Одоогоор Рамсарын конвенц нь 2009-2015 онд хэрэгжүүлэх гуравдахь стратеги төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

Конвенцид нэгдэн орсон Хэлэлцэн тохирогч талууд

Конвенцид нэгдэн орсон Хэлэлцэн тохирогч талууд нь Рамсарын конвенцийн бодлого гаргадаг үндсэн нэгж юм. Талууд нь тухайн улс орны Засгийн газрын байгууллага байдаг бөгөөд конвенцийн үндэсний тайланг бичиж Нарийн бичгийн дарга нарын газарт илгээнэ. Талуудын Бага хурлын ээлжит хуралдаанаар талуудын ажлын төлөвлөгөө, санхүүгийн зохицуулалт, талуудын үйл ажиллагаанд зөвлөлгөө өгөх ба үүссэн болон өрнөж буй хүрээлэн буй орчны асуудлуудыг авч хэлэлцэнэ. Гишүүн бус улсуудын төлөөлөл, Засгийн газар хоорондын хүрээлэн, бүс нутгийн болон олон улсын төрийн бус байгууллагууд талуудын хуралд санал өгөх эрхгүйгээр оролцож болно.

Талуудын Бага хурлын ээлжит хуралдаан бүр нь хэд хэдэн техникийн ажлын хэсэгт хуваагдаж, хэсэг тус бүр нь конвенцийн үндсэн зорилгын хүрээнд ус намгархаг газар, түүний хамгаалал, ашиглалтын талаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээний саналыг дэвшүүлнэ.

Талуудын Бага хурлын ээлжит ба ээлжит бус хуралдааны танилцуулга болон бусад материалыг Нарийн бичгийн дарга нарын газраас нэгтгэн хурлын эмхтгэлийг хэвлэх, эсвэл диск дээр хуулах замаар талуудад тараана. Энэхүү эмхтгэл нь дараах агуулгатай. Үүнд:

- Хуралдааны тайлангийн товчлол
- Хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэр, санал, зөвлөмж

- Оролцогч талуудын жагсаалт
- Талуудын үндэсний илтгэл
- Бусад мэдээлэл

Энэхүү эмхтгэл болон хурлын бусад нэмэлт мэдээлэл Рамсарын конвенцийн вебсайтад гэрэл зургийн хамт гарна.

Талуудын Бага хурлын ээлжит хуралдаан эхлэхээс 6 сарын өмнө талууд үндэсний тайлангаа конвенцийн нарийн бичгийн дарга нарт илгээнэ. Талуудын үндэсний илтгэлээ явуулсан байдлыг харьцуулан үзвэл 1999-2010 онд 84-97% байжээ.

Талуудын бага хурлыг зохион байгуулсан байдлыг дараах хүснэгтээр үзүүлэв.

<i>ДД</i>	<i>Талуудын ээлжит хурал болсон хот, улс</i>	<i>Талуудын ээлжит хурал болсон он</i>	<i>Талуудын ээлжит бус хурал болсон хот, улс</i>	<i>Талуудын ээлжит бус хурал болсон он</i>
1	Cagliari, Italy,	1980	Paris, France	1982
2	Groningen, Netherlands	1984	Regina, Canada	1987
3	Regina, Canada	1987		
4	Montreux, Switzerland	1990		
5	Kushiro, Japan	1993		
6	Brisbane, Australia	1996		
7	San Josй, Costa Rica	1999		
8	Valencia, Spain	2002		
9	Kampala, Uganda	2005		
10	Changwon, Republic of Korea	2008		
11	Bucharest, Romania	2012		

Конвенцийн Байнгын хороо

Байнгын хороо нь Талуудын Бага хурлын ээлжит ба ээлжит бус хуралдаанаар гарсан тогтоол, шийдвэрийн хүрээнд хуралдаан бүрийн хоорондох хугацаанд үйл ажиллагаагаа явуулдаг олон талт үүрэгтэй туслах нэгж мөн. Байнгын хорооны гишүүдийг Талуудын Бага хурлаас 3 жилийн хугацаатай сонгоно. Байнгын хорооны гишүүн нь бүс нутгуудыг төлөөлөн сонгогдоно.

Конвенцийн Байнгын хороо болон хорооны гишүүд нь өөрийн төлөөлж буй бүс нутаг, олон улсын уулзалтанд оролцож, Рамсарын конвенцитай холбоо бүхий сэдвээр зөвлөгөө өгөх, ажлаа сурталчлах, Байнгын хорооны хурал болохоос өмнө бүс нутгийн бүлгүүдийн саналыг авах, хэлэлцэх, бүс нутгийн уулзалтыг Нарийн бичгийн дарга нарын газарт хүргэх, Байнгын хороогоор байгуулагдсан дэд хэсгүүдийн гишүүний үүргийг гүйцэтгэх, Байнгын хорооны дарга, дэд дарга, Нарийн бичгийн дарга нарын газрын шаардсан материалыг бэлтгэн хангах үүрэгтэй. Мөн Байнгын хороо жил бүр ялангуяа Талуудын Бага хурлын хуцралдааны өмнө хуралдана.

Байнгын хороо нь туслах үүрэг бүхий Санхүү, Талуудын уулзалт, Стратеги төлөвлөгөө, Мэдээлэл, боловсрол, олон нийтийн сурталчилгааны ажлын хэсэг, Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсэг, Ad Hoc ажлын хэсэг гэсэн дэд хороотой.

Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсэг

Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсэг нь Конвенцийн талууд, Байнгын хороо, Нарийн бичгийн дарга нарын газарт шинжлэх ухаан, техникийн зөвлөгөө өгөх үүрэгтэй. Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсгийн төлөөлөгчид болон дэмжигчид нь Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсгийн тухайн улсаас томилогдсон төлөөлөгчөөр дамжуулан үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүлээн авч, Байнгын хороо болон Рамсарын талуудад хүргэнэ. Конвенцийн Шинжлэх ухаан, техникийн хяналтын ерөнхий ажлын хэсэг нь Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсгийн шинжээч болон Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсгийн тухайн улсаас томилогдсон төлөөлөгчөөс тогтоно.

Нарийн бичгийн дарга нар

Нарийн бичгийн дарга нарын газар Конвенцийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Нарийн бичгийн дарга нарын газар нь Ерөнхий нарийн бичгийн даргын удирдлага доор ажиллана. Ерөнхий нарийн бичгийн дарга нь Байнгын хороонд материал хүргэх, асуултанд хариулах, мөн бодлого, техник, харилцаа холбоо, ажилчид, сайн дурын албан хаагч нарын өдөр тутмын ажлыг удирдана.

МОНГОЛ УЛС БА РАМСАР

Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Конвенцид манай улс 1998 оны 4 сарын 8-ны өдөр албан ёсоор нэгдэн орсон бөгөөд тус конвенциор баталгаажиж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн болзол шаардлагуудыг хангаж, конвенцийн үйл ажиллагаанд тогтмол оролцож ирсэн байна.

Рамсарын жагсаалтад манай орны 11 газар бүртгэлтэй. Үүнд: Монгол Дагуур (1997), Нууруудын хөндийн нуурууд (1998), Өгий нуур (1998 он), Тэрхийн Цагаан нуур (1998), Хар-Ус нуур (1999), Айраг нуур (1999), Ачит нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Буйр нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Ганга нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Увс нуур, түүний орчмын ус, намгархаг газар (2004), Хурх, Хүйтэн голын хөндийн нуурууд (2004).



Онон голын хөндий

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Рамсарын жагсаалтад бүртгэлтэй дээрх газруудаас одоогийн байдлаар 7 нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт орсон тул Тусгай хамгаалалттай газар нутгийн хүрээнд хамгааллын зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Түүнчлэн Усны тухай хууль, Амьтны аймгийн тухай хууль, Усны үндэсний хөтөлбөр, Биологийн олон янз байдлыг хамгаалах шйл ажиллагааны хөтөлбөр зэрг хууль эрхийн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд конвенциор хүлээсэн үүргээ сахин

биелүүлж байгаагаас гадна ус, намгийн шувуудын зарим төрөл зүйлийг Монгол улсын хууль тогтоомжоор нэн ховор, ховор амьтны жагсаалтад хамруулах, Монгол улсын "Улаан ном"-д оруулах замаар хамгаалах арга хэмжээ авч байна.

Конвенцийн хэрэгжилтийг хянах, хангах үүрэг бүхий Үндэсний хороог анх 1998 онд Байгаль орчны сайдын тушаалаар байгуулж, 2001 ба 2010 онд тус тус шинэчлэн баталжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны А-88 тоот тушаалаар Үндэсний зөвлөлийн даргаар БОАЖЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Д.Батболд, Нарийн бичгийн даргаар тус газрын мэргэжилтэн Б.Саранцэцэг, (2010 онд Х.Майцэцэг), гишүүдээр БОАЖЯ-ны Улсын тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга А.Намхай, БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын мэргэжилтэн П.Цогтсайхан, ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн Шувуу судлалын лабораторийн эрхлэгч Н.Цэвээнмядаг, МУИС-ийн Биологи, биотехнологийн сургуулийн Шувуу судлалын лабораторийн эрхлэгч С.Гомбобаатар, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын ажилтан М.Хулан нарыг томилсон байна.

Монгол улсыг Рамсарын конвенцид төлөөлөх эрхтэй тал бол манай улсаас Байгаль орчин, аялал жуулчлалын яам, харин уг яамыг конвенцийн өмнө БОАЖЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Д.Батболд төлөөлнө. Ус намгархаг газар, усны шувуудын талаарх мэдээ, баримт, мэдээллийн сан, ялангуяа нүүдлийн усны шувуудын тухай асуудлаар хавсралт 1-д дурдсан хүмүүстэй холбогдон цаашид хамтран ажиллаж болно.

Рамсарын конвенцийн Шинжлэх ухаан, техникийн хяналтын ерөнхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн болсон Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсгийн тухайн улсаас томилогдсон төлөөлөгчөөр МУИС-ийн багш С.Гомбобаатар 2010 оноос ажиллаж байна.

Конвенцийн Мэдээлэл, боловсрол, олон нийтийн сурталчилгааны ажлын хэсэгт манай улсыг төлөөлсөн ажлын хэсгийн төлөөлөгчөөр Дэлхийн байгаль хамгаалах сангийн ажилтан М.Хулан ажиллаж байгаа юм.

КОНВЕНЦИД НЭГДЭХЭЭС ӨМНӨХ УС НАМГАРХАГ ГАЗРУУДЫН СУДАЛГАА, ХАМГААЛЛЫН АЖЛЫН ТОЙМ

Манай улс Рамсарын Конвенцид нэгдэж орохоос өмнө томоохон нуур, голыг тусгай хамгаалалтанд авах, биологийн олон янз байдлын судалгааг бусад судалгааны ажлын хавсарга байдалтай гүйцэтгэж ирэв.

“Монгол улс ба Зүүн Хойд Азийн Ус намгархаг газрын хамгаалал” Олон улсын бага хурлыг 1997 оны 9-р сарын 16-19-д Улаанбаатар хотноо Байгаль орчны яам, Wetlands International Asia Pacific байгууллага хамтран зохион байгуулсан ба энэхүү ажлыг Японы “Кеиданрен” байгаль хамгаалах сан, Японы хүрээлэн буй орчны агентлаг, мөн Монголын “Хөгжил ба хүрээлэн буй орчин” төрийн бус байгууллага хамтран ивээн тэтгэв. Энэ хурлаар манай улсын ус намгархаг газар болон усны шувуудын одоогийн төлөв байдал, цаашид хэрхэн ажиллах тухай авч хэлэлцсэн нь Рамсарын конвенцид нэгдэн ороход чухал алхам болжээ.

Конвенцид нэгдэж орохоос өмнө Байгаль орчны яам манай орны ус намгархаг газрыг гол, нуур, цэнгэг устай намгархаг газар, гүнзгий устай намаг, давслаг устай намгархаг газар гэсэн бүлэгт ангилж нийт 3800 гол, горхи, 3500 гаруй нуур, 6900 том жижиг цөөрөм, намгархаг газрыг бүртгэсэн байна (Adiyasuren, 1998).

Байгаль орчны яамнаас 1998 оноос хэрэгжүүлсэн ажлуудыг ерөнхийлөн нэгтгэвэл дараах чиглэлтэй байна. Үүнд:

Ус намгархаг газрыг хамгаалах хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх талаар:

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах хууль (1995), Газрын хууль (1995), Газрын төлбөрийн тухай хууль (1997), Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1995), Усны тухай хууль (1995), Ус ашигласны төлбөрийн тухай хууль (1995), Байгалийн ургамлын тухай хууль (1995), Ойн тухай хууль (1995), Ой, хээрийн түүмрээс хамгаалах тухай хууль (1996), Ан агнуурын тухай хууль (1995), Агаарын тухай хууль (1995), Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль (1995) зэрэг хуулийг батлав.

Ус намгархаг газрыг тусгай хамгаалалттай газар нутагт хамруулах талаар:

Увс нуур, Монгол Дагуур, Хан Хэнтийн Хагийн Хар нуурыг Дархан цаазат газар, Хөвсгөл, Тэрхийн Цагаан нуур, Хар –Ус нуур (Хар болон Дөргөн нуур), Горхи Тэрэлж (Туул голын зарим хэсэг), Алтайн нурууны нуурууд (Хотон, Хоргон, Даян, Толбо нуур)-ыг Байгалийн цогцолбор газарт, Булган голыг Байгалийн нөөц газарт, Хүйсийн найман нуур, Ганга нуурыг Байгалийн дурсгалт газарт оруулжээ.

Ус намгархаг газрын үнэлгээ ба хамгаалах боломжийн талаар:

Усны гидрологийн үнэлгээ, гүний усны чанар, үерийн урсац, түүний өөрчлөлт, тунадасжилт, хорт бодисын хуримтлал, биологийн олон янз байдлын үнэлгээ зэргийг 95 гол, 14 нууранд хийжээ.

Ус намгархаг газрын мониторингийн судалгааны талаар:

Ус намгархаг газрын морфологи, гидрологи, ургамалжилт, амьтны аймаг, усны чанар зэрэг үзүүлэлтийг 122 голд хийж гүйцэтгэсэн ба ус намгархаг газарт буй зарим зүйлүүдийг хамгаалахын тулд агнуурыг хориглох, олон улсын шувууны нүүдлийн замын

сүлжээнд буй улс орнуудтай гэрээ байгуулан ажиллах, шаардлагатай нөхцөлд биотехникийн арга хэмжээ авах, Монгол улсын Улаан ном (1997)-д оруулах зэрэг үйл ажиллагааг явуулж байна. Нийт 325 зүйлд хамаарах ус намгархаг газрын ургамлыг тодорхойлон бичиглэсэн ба эдгээрийн олонх нь урсгал усанд дасан зохилдсон хэт чийгсэг нөхцөлд зохилдсон байна (Ganbold & Tsetsegmaa, 1998).

Усны болон амьдрал нь устай холбоотой шувуудыг хамгаалах зорилгоор Монгол улсын Улаан номд оруулсан бөгөөд эдгээр шувуунд нөлөөлөгч хүчин зүйл бол хулгайн агнуур, уул уурхай, усан цахилгаан станц, мал, шинээр машин зам, төмөр зам, өндөр хүчдэлийн шугам барих зэрэг болно.

Ус намгархаг газрын хамгааллын талаар:

Ус намгархаг газрыг хамгаалах зорилгоор Олон улсын хамтын ажиллагааг дэмжин ажиллаж ирсэн ба хүрээлэн буй орчны чиглэлээр хамтарсан гэрээнд Монгол улс – БНХАУ-ын хооронд (1990), Монгол улс - Киргизстан улсын хооронд (1993), Монгол улс – ОХУ-ын хооронд (1994) гарын үсэг зурсан ба Дагуурыг хамгаалах чиглэлээр Монгол улс-БНХАУ-ОХУ-ын хамтын ажиллагааны гэрээг 1994 онд байгуулав. Мөн 1994 онд Монгол улс-БНХАУ-ын хил дамнасан усан санг хамгаалах, тогтвортой ашиглах хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зуржээ.

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРСНООС ХОЙШХИ УС НАМГАРХАГ ГАЗРУУДЫН СУДАЛГАА, ХАМГААЛЛЫН АЖЛЫН ТОЙМ

Монгол улс 1998 оны 4-р сарын 8-д Конвенцид нэгдэн орсны дараа нийт 1,439,530 га талбай бүхий 11 газрыг Олон улсын хувьд ач холбогдолтой газраар тодорхойлсон нь Рамсарын конвенцид нэгдсэн орсны дараах томоохон ажлуудын нэг болов.

ОЛОН УЛСЫН ХУВЬД АЧ ХОЛБОГДОЛТОЙ РАМСАРЫН ЖАГСААЛТАД БҮРТГЭЛТЭЙ ГАЗАР НУТГУУД

МОНГОЛ ДАГУУР (1997)

Товч танилцуулга

Олон улсын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалтад 1997 оны 8-р сарын 12-нд оруулсан. Нийт талбайн хэмжээ 210,000 га. Солбицол: 49°42'N 115°06'E. Монгол Дагуур нь “А”, ”Б” хэсгээс тогтох Дархан цаазат газар юм. Тектоникийн хөдөлгөөнөөр үүссэн ба уудам хээр, ус намгархаг хөндийтэй, мөн олон том, жижиг гол, нууруудтай, олон зүйл эндемик ургамлыг агуулсан нутаг юм. Нийт 260 зүйл шувуудын хооллох, үржих, өвөлжих, дайрч өнгөрөх чухал газар бөгөөд нийт 6 зүйл тогорууны өлгий нутаг мөн. Нутгийн малчид энд голоо бараадан амьдарна. Цөөн хэдэн тариалангийн талбай бий. Рамсарын бүртгэлийн дугаар 924.



Монгол Дагуурын ус намгархаг газрууд бол усны шувуудын амьдрах тааламжтай нутаг

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Өнгөрсөн хугацаанд болон одоогоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төлөв байдал

БОАЖЯ, Дорнодын ДЦГ-уудын Дорнод хамгаалалтын захиргаа, Дорнод аймгийн Байгаль орчны газар хамтран Монгол Дагуурын ДЦГ-ын болон Дашбалбар, Чулуунхороот сумдын байгаль хамгаалагч нар биологийн олон янз байдлыг судлах, хамгаалах чиглэлээр санаачилгатай ажиллаж байна.

Байгаль орчны яам, Шинжлэх ухааны академи, Дорнод аймгийн тамгын газар, Дархан цаазат газрын Хамгаалалтын захиргаа, Олон улсын байгууллага хамтран 2003 оны 8 сарын 26-31-нд Монгол Дагуурын ДЦГ-ын Дөрөө нууранд "Зүүн хойт Азийн тогорууны сүлжээ нутаг дахь сургалт ба менежмент" сэдэвт олон улсын сургалтыг зохион байгуулсан ба сургалтанд ОХУ, БНХАУ, Монголын нийт 55 төлөөлөгч оролцсон ба Англи, АНУ, Японоос багш ирж хичээл заав (Цэвээнмядаг ам мэдээ).



Монгол Дагуурт үрждэг Цэн тогоруу (*Grus vipio*)

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

ШУА-ийн Биологийн хүрээлэн, Дорнодын ТХГ-уудын Дорнод хамгаалалтын захиргаа, Дэлхийн Байгаль орчны Японы итгэмжлэгдсэн байгууллага хамтран Монгол Дагуурын ДЦГ, түүний орчмын ус намгийн шувууд, Монгол Дагуурын ДЦГ-ын ховор шувуудын талаарх тараах материал, гарын авлагыг 2004 онд хэвлүүлэв (Цэвээнмядаг, 2004).

МУИС болон Монголын шувуу судлалын нийгэмлэг нь Олон улсын Working Group International Waterbird & Wetland Research (WIWO) байгууллагатай хамтран 2005 онд Монгол орны дорнод бүс нутгийн нуурууд, тухайлбал, Монгол Дагуурын дархан цаазат

газрын зарим нуурууд нь Азийн сүвээцагаан (*Pluvialis fulva*) шувууны хувьд онцгой ач холбогдолтой болохыг тогтоож, нүүдлийн үедээ шувуудын хооллох зан төрхийн судалгааг гүйцэтгэв (Jeroen *et al.*, 2005; www.mos.mn).

Хөрш зэргэлдээ орнуудын хил дамжин оршдог, Рамсарын конвенцийн жагсаалтад орсон Монгол Дагуурын ДЦГ-ыг ОХУ-ын Даурын ТХГ, БНХАУ-ын Далай нуурын ТХГ-тай хамтарч хамгаалах чиглэлээр гурван улсын холбогдох яам хэлэлцээр байгуулан ажиллаж байна.

ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв, АНУ-ын Оклахама их сургууль, АНУ-ын Геологийн судалгаа, НҮБ-ын ХХАБ, БНСУ-ын Үндэсний шинжлэх ухааны музей, Баруун бүсийн экологийн судалгааны төв хамтран Монгол Дагуурын Хайчийн цагаан, Хорин цагаан, Хөх нуурын Хошуу галуу (*Anser cygnoides*) /25 бодгаль/, Гангар хун (*Cygnus cygnus*) /15 бодгаль/-д сансарын дамжуулагч, 60 гаруй Хошуу галуу (*Anser cygnoides*) -нд бөгж, хүзүүвч зүүж нүүдлийг судлахад Гангар хун Хятад, Өмнөд солонгос, Хошуу галуу Хятадын Хөх мөрөнд очиж өвөлжиж буйг тогтоожээ (Биологийн хүрээлэнгийн ЭШ-ний 2006-2011; Nyambayar *et al.* 2011; Newman *et al.* 2009). Мөн дээрх байгууллагууд хамтран Хорго-Тэрхийн Цагаан нуурын БЦГ-ын шувуудын бүрдэл, оршин амьдрах хэлбэрийг тодруулж, энд нийт 6000 орчим Хээрийн галуу (*Anser indicus*) жил бүр гуужиж, Энэтхэгт очиж өвөлждөг болохыг 2008-2011 онд тогтоов (Биологийн хүрээлэнгийн ЭШ-ний тайлан 2008-2011; Taekawa *et al.*, 2009; Prosser *et al.*, 2009).

НУУРУУДЫН ХӨНДИЙН НУУРУУД (БӨӨН ЦАГААН, ТААЦЫН ЦАГААН, АДГИЙН ЦАГААН, ОРОГ НУУР) (1998)

Товч танилцуулга

Олон улсын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалтад 1998 оны 7-р сарын 6-нд оруулсан. Нийт талбайн хэмжээ 45,600 га. Солбицол: 45°19'N 099°58'E. 1,100 м-ээс 1,235 м өргөгдсөн Говь Алтайн нурууны бэлээр орших дөрвөн томоохон нуурын систем бөгөөд гүехэн устай, усны төвшин жил, улирал, хур тунадаснаас хамааран хэлбэлзэнэ. Эдгээр нуур нь нүүдлийн усны шувуудын бууж амрах, хооллох, зусах, үржих чухал нутаг болно. Энэ нууранд Реликт цахлай (*Larus relictus*) өндөглөнө. Нуур нь хүн малыг ундаалах усны үүсвэр юм. Рамсарын бүртгэлийн дугаар 954.

Өнгөрсөн хугацаанд болон одоогоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төлөв байдал

Биологийн хүрээлэн, Шувуу судлалын сан, Монгол-Оросын хамтарсан экспедици Бөөнцагаан нуурт 6 удаагийн хайгуул судалгааг гүйцэтгэж нийт 161 зүйл шувууны зүйлийн бүрдэл, оршин амьдрах хэлбэр, зарим ховор шувуудын биологи, экологи, тоо толгойн талаар өгүүлэл хэвлүүлэв (Болд, 2005).

МУИС-ийн Шувуу судлалын нийгэмлэг, Японы Шувуу судлалын Ямашина хүрээлэн, Олон улсын ОИЕ байгууллага, Байгаль орчин, аялал жуулчлалын яам хамтран Бөөнцагаан нуурын шувуудын зүйлийн бүрдэл, Гангар хун (*Cygnus cygnus*)-ийн нүүдлийг сансарын дамжуулагч багажийн тусламжтай судлах ажлыг 2011 оны 7-р сард хийж

гүйцэтгэсэн ба Бөөнцагаан нуур болон Өвөрхангай аймгийн Сангийн далай нуурт үржиж, зуссан Гангар хун Хятадын хойд нутагт хүрч өвөлждөг болохыг анхлан тогтоов. Гангар хунгийн цус болон бусад дээжнээс шувууны ханиад илрүүлэх судалгааг Мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори болон Японы Хоккайдагийн их сургуулийн Мал эмнэлгийн сургууль гүйцэтгэж байна (Гомбобаатар ба бусад, 2011; www.mos.mn).

ӨГИЙ НУУР (1998)

Товч танилцуулга

Олон улсын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалтад 1998 оны 7-р сарын 6-нд оруулсан. Нийт талбайн хэмжээ 2,510 га. Солбицол: 47°46'N 102°46'E. Галуу, нугасны овгийн шувууд (Anatidae)-ын сүлжээ нутаг. Орхон голын хөндийд байрлах цэнгэг устай нуур. Голын өргөн хөндий, гол ба нуурыг холбосон жижиг гол, цөөрөм, намаг ихтэй хээржүү газар юм. Нуурын хамгийн гүн нь 16 м хүрэх ба нуурын талбайн 40% 3 м-ээс гүнгүй. Энэ нуураас хүн, мал ундаалах ба мөн загас агнуур хөгжсөн. Олон зүйл усны шувуудын бууж амрах, дайрч өнгөрөх, зусах, үржих тохиромжтой нутаг бөгөөд ялангуяа галуу, нугасны овгийн олон зүйл шувууд энд гууждаг. Рамсарын бүртгэлийн дугаар 955.



Өгий нуур

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Өнгөрсөн хугацаанд болон одоогоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төлөв байдал

Өгий нуур болон Орхон голын сав газар орчмын ус зүй, экологийн цогц судалгааг 2005-2006 онд гидрологи, усны чанар, усны шавьж, загас, шувуу, хөхтөн, (2 нутагтан, мөлхөгч хамт), ургамал, фито планктон, зоо планктон гэсэн 9 чиглэлээр хийсэн. Судалгаагаар Өгий нуур, Орхон голын сав газарт 266 зүйл ургамал, 128 зүйл шувуу, 14 зүйл загас, 19 зүйл хөхтөн, 1 зүйл 2 нутагтан, 3 зүйл мөлхөгч бүртгэгджээ.

Биологийн хүрээлэн, Шувуу судлалын сан, мөн Өгий нуурын экосистемийг хамгаалах ЖАЙКА-гийн төслөөр Өгий нуур орчим нутгийн шувууд өгүүлэл, гарын

авлагыг хэвлүүлж, энэ нуурыг цаашид хамгаалах, зүй зохистой ашиглах менежмент боловсруулах эх тулгуур материалыг бүрдүүлэв (Цэвээнмядаг ба Болд, 2005; Өгий нуурын экосистемийг хамгаалах төслийн тайлан (2005, 2006).

Орхон голын сав газарт орших Өгий нуурын ус, намгархаг газрын экосистемийг хамгаалах, тухайн бүс нутгийн байгалийн баялгийг цаашид зүй зохистой ашиглах аргачлалыг бий болгох зорилго бүхий “Ус, намгархаг газрын экосистемийг хамгаалах, зохистой ашиглах, голын сав газрын менежментийн загвар төсөл”-ийг 2005-2010 он хүртэлх хугацаанд Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАИКА)-ын санхүүжилтээр хэрэгжүүлсэн. Энэ төсөл нь Монгол орны Рамсарт бүртгэгдсэн болон бусад ус намгархаг газрыг хамгаалах загвар болох үр дүнтэй ажил болов.



Энэ нутагт үржиж буй Гангар хун (*Cygnus cygnus*) ба түүний дэгдээхий

Гэрэл зургийг С.Гомбобаатар©


БОАЖЯ болон Архангай аймгийн Өгий нуур сумын захиргаа, Японы ЖАИКА байгууллага 2009 оноос хамтран Өгий нуурын мэдээлэл, сургалтын төв байгуулж, орон тооны захиргаа бий болгожээ.

БОАЖЯ, Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАИКА, Архангай аймаг хамтран Өгий нуурын ус намгархаг газрын экосистемийг хамгаалах, зохистой ашиглах голын сав газрын менежментийн загвар төслийн хүрээнд Өгий нуур, түүний сав газрын экосистемийг хамгаалах зарчим, голын сав газрын менежментийн хөтөлбөрийг боловсруулав (*Өгий нуурын экосистемийг хамгаалах төслийн тайлан*, 2005 ба 2006.)

ТЭРХИЙН ЦАГААН НУУР (1998)

Товч танилцуулга

Архангай аймгийн нутагт оршино. Олон улсын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалтад 1998 оны 7-р сарын 6-нд оруулсан. Нийт талбайн хэмжээ 6,110 га. Солбицол: 48°10'N 099°43'E. Байгалийн цогцолборт газар ба галуу, нугасны овгийн шувуудын сүлжээ нутаг. Цэнгэг устай, галт уулын үйл ажиллагаагаар үүссэн, Хангайн төв хэсгийн Суман голын хөндийд байрлана. Манай орны бусад ус намгархаг газрын адил мал ундаалах ба загас барих үйл ажиллагаа тохиолдоно. Томоохон намгархаг газар нь нүүдлийн усны шувуудын үржих, хооллох чухал нутаг болно. Рамсарын бүртгэлийн дугаар 953.



Олон тоотой зусаж, нүүдэллэдэг Гэээгт шумбуур (*Aythya fuligula*)

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Өнгөрсөн хугацаанд болон одоогоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төлөв байдал

ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв, Хорго-Тэрхийн Цагаан нуурын БЦГ-т Рамсарт бүртгэлтэй Тэрхийн Цагаан нуурын усны шувуу, экосистемийг хамгаалах зорилгоор сурталчилгааны зурагт хуудас хийж орон нутгийн удирдлага, хамгаалалтын захиргаанд өгсөн ба мөн нутгийн иргэдэд ухуулга сурталчилгааны ажил хийв. Мөн Wetlands International, BirdLife International, БОАЖЯ, Биологийн хүрээлэн 2011 онд Монголоос Монгол Дагуур, Өгий нуур, Тэрхийн Цагаан нуур, Хурх-Хүйтэн голын хөндий, Угтамын БНГ-ыг Зүүн Ази-Австрали Азийн шувууны нүүдлийн зам дагуух хамтын ажиллагааны түншлэлд хамруулах үндэслэл бэлтгэж өгсөн (Н.Цэвээнмядаг ам мэдээ).

АЙРАГ НУУР (1999)

Товч танилцуулга

Увс аймгийн Айраг нуурыг 1999 оны 4-р сарын 13-нд Олон улсын ач холбогдолтой нутгийн жагсаалтад оруулжээ. Нийт талбайн хэмжээ 45,000 га. Солбицол: 48°53'N 093°25'E. Их нуурын хотгорын гүехэн, цэнгэг устай нуур бөгөөд үржиж, зусдаг усны шувуудын хувьд ихээхэн ач холбогдолтой төдийгүй Борцгор хотон (*Pelecanus crispus* шувууны үрждэг чухал нутаг болно. Мөн олон улсын хувьд ховор Хошуу галуу болон Реликт цахлайн хувьд чухал газар юм. Нуур орчимд нутгийн малчид нүүдэллэн амьдарна. Рамсарын бүртгэлийн дугаар 977.

Өнгөрсөн хугацаанд болон одоогоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төлөв байдал

Айраг нуурын шувуудын судалгааг нэгтгэн, Айраг нуур ба түүний орчим нутгийн шувууны тойм бүтээлийг хэвлүүлэв (Болдбаатар, 2007).

Дэлхийн байгаль хамгаалах сан энэ нуурын биологийн олон янз байдал, усны экосистем, нөөц баялгийг зүй зохистой ашиглан хамгаалах төслийг хэрэгжүүлэв. Тэдний судалгаагаар “Завхан голын урсац сүүлийн жилүүдэд багассан үндсэн шалтгаан бол 1990-иэд оны дунд үеэс өнөөг хүртэл үргэлжилж буй услаг багатай байгалийн мөчлөг, уур амьсгалын ерөнхий дулаарал болно. Тухайлбал, Завхан голын нэг эх болсон Шар усны гол 1998 оноос хойш бараг жил бүр тасарч, урсацгүй байх тохиолдол, хугацаа нэмэгдэх хандлагатай болжээ. 2007 оноос Завхан гол дээр Улаан боомын чиглэлээр Усан цахилгаан станц барьж голын усыг далангаар хааж, ус хуримтлуулах болсон нь олон жил үргэлжилсэн ган гачгийн үед нэрмээс болж Улаанбоомын УЦС-аас доош Завхан голын урсац 2007, 2008 онуудад эрс багасан олон газар тасарч, улмаар Айраг нуурт цутгах хэмжээ ихээхэн багассан байна. Улаанбоомын УЦС-ын нөлөөлөл нь түүний дээр буюу ус судлалын Завхан-Гуулин харуул ба доор байрших ус судлалын Завхан-Тайшир харуулын урсацын хэмжилтээс тод харагдана. Завхан-Гуулин ба Завхан-Тайширын олон жилийн дундаж урсац нь 8.85 ба 8.64 м³/сек байдаг. УЦС баригдсаны дараах 2007, 2008 онд Завхан-гуулин харуулын жилийн дундаж урсац 5.41. 5.44 м³/сек бол мөн жилүүдэд Завхан-Тайширын жилийн дундаж урсац УЦС-ын нөлөөгөөр 1.49, 0.17 м³/сек болтол буурсан байна. Энэ бүхнээс үзэхэд УЦС урсгалын доод чиглэлд ямар хэмжээний нөлөө үзүүлж буй нь тодорхой байна. Завхан голын нэг эх болох Шар усны гол бараг нийт уртын дагуудаа хатаж ширгэсэн харин Хар усны гол бага зэрэг устай байлаа. Харин Завхан голын томоохон цутгал болох Чигэстэй, Богд, Буянт голууд нь 2011 оны 7 дугаар сарын хоёрдугаар арав хоногийн эхээр үерлэн Богд голын их өнгөрөлт 100 м³/сек шахам (6.46), Чигэстэй-19.9 (4.51) болон Буянт голын өнгөрөлт 33.1 м³/сек (11.9) хүрсэн нь олон жилийн дунджаас хол давсан их өнгөрөлт байв. Энэ үерийн ус Борх-Шураг (Яруу, Богд) голоор дамжин Завхан голд хүрч Цагаан арлын гарамаас доош Завхан голын өнгөрөлт 4.34 болж улмаар Дөрвөлжин сумын орчим 10.0 орчим м³/сек хүрч, Завхан гол боломжийн устай болсон байна. Харин Дөрвөлжингөөс цааш Завхан гол 200 км гаруй Монгол элсийг эмжин, ус алдагдсаар Айраг нуурт дөнгөж 0.30 м³/сек ус цутгаж байлаа. Завхан голын сав газар бол гол-нуурын гэсэн хоорондоо ихээхэн эмзэг уялдаа холбоо бүхий байгалийн маш нарийн, нэгдмэл систем байх тул байгаль орчин, экологийн талаас Сав газрын болон усны нөөцийн нэгдсэн менежментэд төдий хэмжээгээр онцгой байр суурь эзлэх нь

ойлгомжтой юм. Мөн түүнчлэн усан орчин ба усны эрчим хүчний үйлдвэрлэл, эсвэл урсгалын дээд ба доод чиглэлийн зөрчлийн асуудал нь сав газрын нэгдсэн менежментийн төлөвлөлтөөр зохицуулагдах нэн тэргүүний асуудал болж хувираад байна.

ХАР-УС НУУР (1999)

Товч танилцуулга

Ховд аймгийн Хар Ус нуурын Байгалийн цогцолбор газар (БЦГ). Олон улсын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалтад 1999 оны 4-р сарын 13-нд оруулсан. Нийт талбайн хэмжээ 321,360 га. Солбицол: 47°58'N: 092°50'E. Энд Хар Ус, Хар, Дөргөн гэсэн нийт гурван нуур багтана. Үргэлжилсэн их зэгс шагшуурга болон усны ургамал нь манай оронд төдийгүй дэлхийд ховор Борцгор хотон (*Pelecanus crispus*), Хошуу галуу (*Anser cygnoides*), Ундар шумбуур (*Aythya nyroca*), Цагаан-толгойт ямаансүүлт (*Oxyura leucocephala*), Реликт цахлай (*Larus relictus*) зэрэг шувуудын өндөглөх таатай орчин болно. Баруун бүс нутгийн эндемик 3 зүйл загас энд амьдарна. Түүхийн болон археологийн хувьд ач холбогдол бүхий газруудыг агуулсан төдийгүй гүний усны эх үүсвэр болдог. Нуурыг тойрон малчид амьдарна. Рамсарын бүртгэлийн дугаар 976.

Өнгөрсөн хугацаанд болон одоогоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төлөв байдал

Хар-Ус нуур, Дөргөний усан цахилгаан станцид Дэлхийн байгаль хамгаалах сангийн техникийн туслалцаатай Алтай Соёны экобүс нутгийн Биологийн олон янз байдал, төрөл зүйл болон усны экосистем, нөөц баялгийг зүй зохистой ашиглан хамгаалах төслийг 2003 онд хэрэгжүүлэв. Энэ ажлын үр дүнд “Дөргөний усан цахилгаан станц төслийг хэрэгжүүлэх нь Баруун бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр хангахад онцгой ач холбогдолтой. Гэвч Далай нуур, Чонохарайх голын гидрохими, гидробиологийн тэнцвэрт харьцаа алдагдах, Далай нуурын усны түвшин өргөгдснөөр нуурын өмнөд хэсэгт орших зэгс шагшуурга бүхий ус намгархаг орчин өртөн зэгс шагшуургын бүлгэмдэл, өвлийн бэлчээрт ашиглагддаг тачир ургамалт хөрсжсөн газар зэрэг биотопийн хэлбэрүүд, түүнийг шүтэн амьдардаг амьтан, ургамлын зүйлийн бүрдэлд өөрчлөлт орох, урьд нь нэгэн цул нэгдмэл байсан амьдрах орчныг баруун, зүүн гэсэн хоёр тусгаарлагдмал орчинд хуваах болно. Энэ нь зарим загасны төрөл болон усны ёроолын амьтдад хүндээр тусах зэрэг сөрөг нөлөө гарна” гэж дүгнэлт өгсөн байдаг.

МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Хустай БЦГ хамтран Рамсарын жагсаалтанд багтсан зарим нуурууд, тухайлбал, Хар-Ус нуурт өвөлжиж буй усны шувуудын тооллого хийж, судалгааны мэдээ, баримтыг нэгдсэн мэдээллийн санд оруулж, мэдээ, баримтыг нэгтгэж, олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлж, хэвлүүлжээ (Gombobaatar, 2004).



Өвөлжиж буй Хондон ангир (*Tadorna ferruginea*)

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв хамтран 2005, 2009-2011 онд Хар Ус нуурын БЦГ, Айраг, Ачит нуурын усны шувуудын бүртгэл, Борцгор хотон (*Pelecanus crispus*)-ийн судалгааг гүйцэтгэж, тоо толгой нь сүүлийн жилүүдэд ихээр цөөрсөн ба яаралтай хамгаалах арга хэмжээ авахгүй бол устахад ойртоод байгааг тогтоов. Судалгааны үр дүнг BirdingAsia сэтгүүлд хэвлэв. Шувууны томууны тандан судалгааны явцад 2011 онд Айраг, Ачит, Буйр нуурын шувууны бүртгэл хийгдсэн ба мөн энэ нуураас гангар хун барьж хүзүүвч зүүх замаар нүүдлийг нь судалж байна. Хар Ус нуурын Гангар хун (*Cygnus cygnus*) Хятадын төв хэсэгт очиж өвөлждөг.

АЧИТ НУУР, ТҮҮНИЙ ОРЧМЫН УС НАМГАРХАГ ГАЗАР (2004)

Товч танилцуулга

Олон улсын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалтад 2004 оны 3-р сарын 22-нд оруулсан. Нийт талбайн хэмжээ 73,730 га. Солбицол: 49°40'N 090°35'E. Ховд голын хөндийн цэнгэг устай гүехэн нуур бөгөөд Монгол Алтайн нурууны системд хамгийн том хэмжээтэй нууруудын нэг бөгөөд өндөр уулсын дунд байрлана. Нуур 11-5 дугаар сар хүртэл мөстэй байна. Монгол улсын төдийгүй олон улсын анхаарал татсан ховор зүйл шувууд энэ нууранд үржинэ. Энэ нууранд Отгот шунгуур (*Podiceps cristatus*), Хар өрөвтас (*Ciconia nigra*), Хондон ангир (*Tadorna ferruginea*) зэрэг шувуудын популяцийн нэгээс илүү хувь нь амьдарна. Хэд хэдэн зүйлийн эндемик зүйл загас бий. Алс зайдуу, очиход хүндрэлтэй учир аялал жуулчлал энэ нууранд хөгжөөгүй. Рамсарын бүртгэлийн дугаар 1376.



Үржлийн Хар өрөвтас (*Ciconia nigra*)

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

БУЙР НУУР, ТҮҮНИЙ ОРЧМЫН УС НАМГАРХАГ ГАЗАР (2004)

Товч танилцуулга

Олон улсын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалтад 2004 оны 3-р сарын 22-нд оруулсан. Нийт талбайн хэмжээ 104,000 га. Солбицол: 47°48'N 117°40'E. Манай орны томоохон цэнгэг устай нууруудын нэг бөгөөд түүний эргэн тойрон олон жижиг нуур, цөөрөм бий. Энэ нуур нь Дагуурын хялганат хуурай хээрийн ургамал, амьтны аймагтай. Халх гол зэрэг гол, нуурын усан хангамжийг зохицуулдаг. Энэ бүс нутагт Цагаан зээрийн (*Procapra gutturosa*) томоохон сүргүүд тогтмол байрших ба 236 зүйл шувуу бүртгэгджээ. Эдгээрээс олон зүйл нь олон улсын хувьд ховор, ховордож байгаа болно. Энэ ус намгархаг газарт загасчдын жижиг суурингаас өөр томоохон суурин газар байхгүй. Уур амьсгалын өөрчлөлт, загас агнуур нь нуурын хэвийн байдалд сөргөөр нөлөөлнө. Рамсарын бүртгэлийн дугаар 1377.



Буйр нуур. Олон зүйл усны болон ус орчмын шувуудын амьдрахад тохиромжтой орчин

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Өнгөрсөн хугацаанд болон одоогоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төлөв байдал

МУИС-ийн Шувуу судлалын лаборатори, Монголын шувуу судлалын нийгэмлэг, АНУ-ын Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, Английн шувуу хамгаалах вангийн нийгэмлэг (RSPB) хамтран Рамсарын жагсаалтад орсон дорнод бүс нутгийн нууруудыг хамруулан Дорнод Монголын шувуудад чухал газрыг тодорхойлох судалгааг 2004 онд хэрэгжүүлж, Монгол орны дорнод бүс нутгийн Рамсарын ажгсаалтад орсон нуурууд, ялангуяа Буйр нуур нь нүүдлийн үрждэг, дайрч өнгөрдөг шувуудын чухал нутаг бөгөөд үндэсний хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутагт оруулах замаар хамгаалах шаардлагатай гэдгийг тогтоов. Мөн Монгол оронд өмнө нь цөөн бүртгэгдсэн шувуудын талаарх баялаг мэдээ, баримтыг цуглуулав (Badley *et al.*, 2005; www.mos.mn).

ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв, Солонгосын Үндэсний шинжлэх ухааны музей хамтран Буйр нуурын Хошуу галуу (*Anser cygnoides*)-ны судалгааг 2006-2008 онд гүйцэтгэв.



Буйр нуурын эрэгт ажиглагдсан Австрали улсад бөгжилсөн Шар-түрүүт элсэг (*Calidris ruficollis*)

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

ГАНГА НУУР, ТҮҮНИЙ ОРЧМЫН УС НАМГАРХАГ ГАЗАР (2004)

Товч танилцуулга

Олон улсын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалтад 2004 оны 3-р сарын 22-нд оруулсан. Нийт талбайн хэмжээ 3,280 га. Солбицол: 45°15'N 114°00'E. Хээрийн жижиг, давсархаг нуур (220 га) ба ус намаг, элсэн манхан, хуурай хээр хосолсон өвөрмөц тогтоцтой. Энэ нуур нь Цэн тогоруу (*Grus vipio*), Хошуу галуу (*Anser cygnoides*), Хонин тоодог (*Otis tarda*) зэрэг олон улсад ховордсон шувууны үржлийн болон нүүдлийн үедээ бууж амардаг чухал нутаг мөн. Энэ нуурын эргэн тойронд нутгийн малчид цөөн тоотой амьдарна. Ганга нуурыг түшиглэн түүхэн дурсгалт газар болон Гангар хун үзүүлэх аяллыг зохион байгуулах боломжтой. Рамсарын бүртгэлийн дугаар 1378.

Өнгөрсөн хугацаанд болон одоогоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төлөв байдал

Ганга нуур, түүний орчмын ус, намгархаг газрын хамгааллын статусыг Байгаль орчны яам, Аймаг орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр дээшлүүлэв. 2004 оны УИХ-ын 22-р тогтоолоор Байгалийн дурсгалт газрыг Даргангын БЦГ болгон хамгааллын статусыг дээшлүүлэв (УИХ-ын 2004 оны 4-р сарын 29-ны 22-р тогтоол).

МУИС-ийн шувуу судлалын лаборатори, Аялал жуулчлалын тэнхим, Монголын шувуу судлалын нийгэмлэг хамтран Гангар хун (*Cygnus cygnus*) ажиглах анхны аялалыг оюутнуудын дунд 2011 оны намар зохион байгуулав.



Дайран өнгөрч буй нүүдлийн Гангар хун (*Cygnus cygnus*)

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

УВС НУУР, ТҮҮНИЙ ОРЧМЫН УС НАМГАРХАГ ГАЗАР (2004)

Товч танилцуулга

Олон улсын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалтад 2004 оны 3-р сарын 22-нд оруулсан. Нийт талбайн хэмжээ 585,000 га. Солбицол: 50°20'N E 092°45'E. ЮНЕСКО-ийн Биосферийн дархан газар. Манай орны томоохон давсархаг нуур бөгөөд нуурын багахан хэсэг ОХУ-ын хилд багтана. Энэ нуур нь цөлийн хээр болон өндөр уулсын системийг холбон оршдог өвөрмөц тогтоцтой. Хамгийн гүн нь 20 м. Өндөр, өтгөн зэгс, шагшуурга бүхий хэсэг, голын цутгал нь нийт 215 зүйл усны шувууд, тэр дотроо олон улсад ховордсон Цагаан-толгойт ямаан-сүүл, (*Oxyura leucocephala*), Хошуу галуу (*Anser cygnoides*) зэргийн үржих, нүүдлийн үедээ амрах, зусахад тохиромжтой орчин болно. Энэ нуур нь олон улсын хувьд ховордсон амьтдаас гадна өвөрмөц ургамлын бүрдэлтэй төдийгүй *Oreoleuciscus potanini*, *Oreoleuciscus pewzowi*, *Oreoleuciscus humilis* гэсэн эндемик зүйл загас ч олдоно. Нуур, түүний орчмын ус намгархаг газар орчимд нутгийн малчид амьдарна. Шувуу ажиглах аялал зохион байгуулахад тохиромжтой. Рамсарын бүртгэлийн дугаар 1379.



Зусаж буй Хошуу галуу (*Anser cygnoides*)

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Өнгөрсөн хугацаанд болон одоогоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төлөв байдал

БОАЖЯ-ны туслалцаатай Увс нуурын ай савын дархан цаазат газрыг Шим мандлын нөөц газрын сүлжээнд 1998 онд хамруулсны дээр Дэлхийн соёл болон байгалийн өвийн бүртгэлд 2003 онд оруулав.

Увс нуурт Дэлхийн байгаль хамгаалах сангийн техникийн туслалцаатай биологийн төрөл зүйл болон усны экосистем, нөөц баялгийг зүй зохистой ашиглан хамгаалах төслийг хэрэгжүүлэв.

ХУРХ- ХҮЙТЭН ГОЛЫН ХӨНДИЙ (2004)

Товч танилцуулга

Олон улсын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалтад 2004 оны 3-р сарын 22-нд оруулсан. Нийт талбайн хэмжээ 42,940 га. Солбицол: 48°18'N 110°34'E. Онон гол руу цутгах Хурх, Хүйтэн голын хөндийн хэсэгт байх ойт хээрийн зааг нутаг. Энэ нутаг нь Сибирийн тайгаас Төв Азийн хээр, Дагуурын хээрийн зүйлүүд, ялангуяа дэлхийд ховор усны шувууд амьдардаг. Рамсарын 6-р шалгуураар Цэн тогорууны (*Grus vipio*) популяцийн 11%, Хархираа тогорууны (*Grus grus*) 3%, Өвөгт тогирууны (*Anthropoides virgo*) 1%, Хар өрөвтас (*Ciconia nigra*)-ын 15% байршина. Нутгийн малчид энэ нутагт амьдарна. Дэлхийн дулаарал энэ хөндийд сөргөөр нөлөөлж байна. Рамсарын бүртгэлийн дугаар 1380.



Хурх голын хөндий

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Өнгөрсөн хугацаанд болон одоогоор гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төлөв байдал

Рамсарын конвенцийн танилцуулга, талуудын бага хурлаас гарсан Чангвоны тунхаглал, бүртгэлтэй газруудын тодорхойлолтыг англи, монгол хэлээр хэвлүүлэн олон нийтийн хүртээл болголоо.

Монголын шувуу судлалын нийгэмлэг, Монгол улсын их сургууль, БОАЖЯ хамтран “Хурх, Хүйтэний хөндийн шувууд” гарын авлагыг 2011 оны 9-11-р сард хэвлэн, тус нутгийн иргэдэд тараасан нь шувуу сонирхох, судлах, хамгаалах ажилд чухал ач холбогдолтой байв (Гомбобаатар ба Жаргалсайхан, 2011; www.mos.mn).



Хурх голын хөндийд нүүдлийн үедээ болон зусах үедээ тохиолдох
Морин тутгалжин (*Numenius arquata*)

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

БОАЖЯ, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Зүүн Ази, Австрали Азийн нүүдлийн замын сүлжээ олон улсын байгууллагын дарга Рожер Женш, судалгаа хариуцсан менежер Чанг Чанг Ёнг Чойг 2011 оны 5-р сард хүлээн авч, Хурх-Хүйтэний хөндийн шувууд гарын авлага бичих санхүү, Эргийн шувууны олон улсын бага хурлыг Монголд зохион байгуулах ажил, цаашид хамтран ажиллах ажлуудын тухай цохон хэлэлцэв (Д.Батболд, С.Гомбобаатар ам мэдээ).

РАМСАРТ БҮРТГЭЛТЭЙ УС НАМГАРХАГ ГАЗАР НУТГИЙН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН БУСАД АЖИЛ

Рамсарын конвенцийн шугамаар БОАЖЯ-ны дэмжлэгтэйгээр 2006 онд 5 хүн Япон улсад, 2010 оны 4 сарын 19-22-ны өдрүүдэд Тайланд улсад зохион байгуулагдсан Рамсарын конвенцийн Мэдээлэл харилцаа холбоо, боловсрол, олон нийтийн сурталчилгааны асуудал хариуцсан үндэсний зохицуулагч нарын уулзалтад болон 2011 оны 5 сарын 17-ноос 7 сарын 6-нд Японы олон улсын хамтын ажиллагааны агентлагаас зохион байгуулсан сургалтанд 3 хүн оролцов.

НҮБ-ын Шувууны томууны төсөл, Улсын мал эмнэлэгийн төв лаборатори, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв хамтран 2007 онд Ганга нуур, түүний орчмын ус, намгархаг газарт зүүн 3 аймгийн байгаль орчин, мал эмнэлгийн ажилтнуудад шувууны томуугийн талаар сургалт, сурталчилгааны ажлыг хийв.

БОАЖЯ, BirdLife International, World Bank, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв хамтран 2007-2009 онд “Монгол орны шувуудад чухал газрууд бүтээл”-ийг хэвлүүлэв. Манай улсын шувуудад чухал газрын 20% нь одоогоор Рамсарт бүртгэгдсэн газруудтай дангаар болон хэсэгчлэн давхардсан байдаг. Шувуудад чухал газруудын мэдээллийг онлайн болгож ШЧГ бүрийн мэдээллийг pdf байдлаар, GIS файлыг нь татаж авах боломжтой болгосон (<http://wscc.org.mn/iba.html>).

Монгол улсын нэгдэн орсон байгаль орчны чиглэлийн 11 конвенци, 3 протоколийн эх бичвэрүүдийн монгол орчуулгыг Гадаад харилцааны ямаар хянан баталгаажуулж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2010 оны 3 сарын 31-ний өдрийн №9-д албан ёсоор хэвлүүлэн, хүлээж авч, салбарын холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөв.

МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Дорнын нүүдэлчид ХХК, ХААИС хамтран Дэлхийн нүүдлийн шувууны өдрийг 2011 оноос эхлэн амжилттай зохион байгуулж байгаа бөгөөд жил бүрийн үйл ажиллагаанд төрийн ба төрийн бус байгууллага, хувь хүн, хувийн компанийн нийт 30 орчим хүмүүс оролцож байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.mos.mn хаягаас авна уу.



Нүүдлийн шувууны өдрийг 2011 онд тэмдэглэх үеэр шувуу ажиглаж, тоолов.

Гэрэл зургийг П.Амартүвшин©

Дэлхийн Банк, Недерландын Вант улсын дэмжлэг, санхүүжилт, Лондоны амьтан судлалын нийгэмлэг, Монголын шувуу судлалын нийгэмлэг болон МУИС хамтран Монгол орны шувуудын үндэсний мэдээллийн санг Олон улсын байгаль хамгаалах холбооны стандартын дагуу байгуулсан нь Монгол орны Рамсарт орсон бүхий л нутагт тохиолдох бүх зүйл шувуудын дэлгэрэнгүй мэдээлэл, мэдээ, баримтыг тусгасан үндэсний анхны томоохон ажил боллоо (Gombobaatar, Monks *et al.*, 2011; www.mos.mn)

НУБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагын Зэрлэг амьтны эрүүл ахуй болон экологийн алба, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв

хамтран 2010-2011 онд Усны шувууд олноор бөөгнөрдөг газруудын мэдээллийг нэгтгэсэн ба мөн Монгол орны усны шувуудын одоогоор Гахуунтан, Шунгууртан, Хотонтон, Өрвийтөн, Галуутаны багийн нийт 53 зүйлийн тархац, тоо толгойн мэдээлэл нэгдсэн системд оруулав. Энэхүү мэдээллийн санд хэвлэлийн мэдээ, судлаачдын хувийн тэмдэглэл, болон сүүлийн үед хийгдэж байгаа усны шувууны судалгааны мэдээллүүд багтав.



Бор галуу (*Anser anser*)-ны үржлийн хос

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Биологийн хүрээлэн, УМЭАЦГ лаборатори, 12 аймгийн мал эмнэлэг, байгаль орчны албаны хамгаалагч, мэргэжилтэн хамтран 2008-2011 онд Монгол орны томоохон 70 гаруй нуур, Рамсарын жагсаалтанд багтсан нууруудыг хамруулан шувууны томуунд өртөх боломжтой шувуудын тоо толгой, тархац, түүний өвчний талаарх мэдээлэл цуглуулав (Шувууны томууг тандах судалгааны тайлан, 2009-2011).

НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагын Зэрлэг амьтны эрүүл ахуй болон экологийн алба, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, АНУ-ын Геологийн судалгааны албаны Баруун бүсийн экологийн судалгааны төв, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв хамтран 2010-2011 онд шувууны томууны газар зүйн мэдээний системийг ашиглалтанд оруулав (<http://www.wbcc.org.mn/birdflu.html>).

Рамсарын конвенцид бүртгэлтэй эдгээр газруудад хууль эрхзүй, бодлогын хүрээнд судалгаа, хамгаалал, сурталчилгааны ажлууд хийгдэж буй боловч бүхий л газруудыг хамарч чадаагүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт багтсан зарим газруудад судалгаа, хамгааллын ажлууд Тусгай хамгаалалттай газар нутгийн ажлын хүрээнд хийгдэж байна.

РАМСАРЫН КОНВЕНЦИД БҮРТГЭЛТЭЙ ГАЗРУУДАД НҮҮРЛЭЖ БУЙ АЮУЛ БА БЭРХШЭЭЛ

- Хавар, намрын цагт гарах түймэр ховор шувууд, тэдгээрийн амьдрах орчин болсон зэгс, шагшуургыг ихээр шатаана. Ялангуяа энэ үзэгдэл Монголын дорнод бүс нутгийн ус намгархаг газарт олон тохиолдоно.
- Зун усаа даган буух малчдын олон тоотойггор зусах, намаржих, өвөлжих малын нөлөөнд энэ бүс нутгийн зэгс, шагшуурга, голын хөндийн өлөн, ширэг ихээр өртөж, улмаар жижиг усан сангууд эрчимтэй хатаж байна.
- Уран, алт зэрэг эрдсийн уурхайн нөлөө усны чанар, усны шувуудын амьдралд шууд болон дам байдлаар сөргөөр нөлөөлнө.
- Голын хөндийн бут, бургасыг малын хашаа барих, ахуйн зориулалтаар ихээр ашиглах нь ус намгархаг газарт сөрөг нөлөө ихтэй.
- Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт зэрэг дэлхий нийтийг хамарсан өөрчлөлтийн улмаас Рамсарын Конвенцид бүртгэлтэй олон гол, горхи, ус намгархаг газар ширгэж байна.
- Дөргөн, Тайширын усан цахилгаан станцын орчмын ус намгархаг газрын ширгэлт, гол болон нуурын усны горим өөрчлөгдөх, түүнээс үүдэн гарах сөрөг нөлөө (Завхан гол тасрах, Ажиг, Эрээн нуур ширгэх болон Айраг, Хяргас нуурт усны төвшинд үзүүлэх сөрөг нөлөө)-г Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд одоо хир тусгаагүй байна.
- Дэлхийн Байгаль хамгаалах сангийн судалгаагаар Завхан голын савын усан орчин ба усны эрчим хүчний үйлдвэрлэл, эсвэл урсгалын дээд ба доод чиглэлийн зөрчлийн асуудал нь сав газрын нэгдсэн менежментийн төлөвлөлтөөр зохицуулагдах нэн тэргүүний асуудал болж байна.
- Хоёр станцын усан санг усаар дүүргэж эхэлснээс хойш тогтмол ажиглалтын цэгүүдийг байгуулсан эсэх, голуудыг боосноос хойш усны тэнцвэрийн нэгдсэн тооцоог сав газрын хэмжээнд шинэчлэн хийсэн эсэх нь тодорхойгүй.
- Нууруудын хөндийн олон нуурууд дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, малын тоо толгой нэмэгдсэн зэрэгтэй холбоотой хатаж байгаа бөгөөд Орог нуур, түүний орчмын ус намгархаг газар бүрмөсөн ширгэжээ.
- Буйр зэрэг загасны нөөцтэй нууруудад ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар загас агнуурыг шинжлэх ухаанд тулгуурлаагүй нөөцийн үнэлгээнд үндэслэн хийж буй нь загас идэшт шувуудын популяцийн хэмжээ, цаашлан нуурын экосистемд бүхэлд нь сөргөөр нөлөөлөх хандлагатай.
- Конвенцид бүртгэлтэй улсын тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны байцаагч болон бусад ажиллагсдын мэдлэг, боловсрол сул байгаа нь судлах, хамгаалах ажлыг сайжруулахад нөлөөлж байна.

РАМСАРЫН КОНВЕНЦИД БҮРТГЭЛТЭЙ ГАЗРУУДАД НҮҮРЛЭЖ БУЙ АЮУЛ БА БЭРХШЭЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗОРИЛГООР ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

А. Конвенцийн үйл ажиллагааны хүрээнд хамрагдах зүйлүүдийг хамгаалах чиглэлээр

- Улаан дансны шалгуураар “Ховор”, эсвэл “Мэдээлэл дутмаг” хэмээн тогтоогдсон зүйлүүд нь Рамсарын жагсаалтад бүртгэлтэй газарт тохиолдож байгаа бол тэдгээрийг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг зүйл бүрт зориулан хийх шаардлагатай. Энэхүү төлөвлөгөөг Ховор зүйлийг хамгаалах улаан дансны Хамгааллын төлөвлөгөө хэсэгт тусгасныг анхаарах нь зүйтэй.
- Рамсарын жагсаалтад орсон нутагт өвөлжиж буй, эсвэл үүрлэх, гуужих, нүүдлийн үед уур амьсгал болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөө гарсан тохиолдолд шувуудыг тодорхой цаг хугацаанд тайван байлгах арга хэмжээг зохион байгуулах, хиймэл үүр, далан барих, мөн үүрлэх нутгийг хамгаалсан хашаа, хаалт барих ажлыг зохион байгуулах нь өгөөжтэй.

Б.Бодлогын чиглэлээр

- Хавар, намрын түймрээс урьдчилан сэргийлэх дотоодын болон хил дамнасан арга хэмжээг нутгийн удирдлагуудтай хамтран төрийн захиргааны байгууллагууд авч хэрэгжүүлэх;
- Биологийн олон янз байдлын Улаан данс болон Зүйлийн хамгааллын төлөвлөгөөг бодлогын баримт бичиг болгоход төрийн ба төрийн бус байгууллагууд хамтран ажиллаж, ус намгархаг газрын ховор зүйлийг хамгаалах үндэсний хэмжээний хамгааллын төлөвлөгөөг боловсруулах;
- Рамсарын жагсаалтад хамрагдсан нутгийн судалгаа, хамгааллын ажлыг амжилттай зохион байгуулах нөхцөл болсон санхүүжилтээр бодлогын хувьд дэмжих;
- Рамсарын жагсаалтад орсон нутгууд болон ТХГН-ийн захиргаатай хамтран сургалт, судалгаа, мэдээлэл сурталчилгааны төвүүд байгуулах боломжийг судлах нь чухал юм.

В.Судалгаа шинжилгээний чиглэлээр

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар, санхүүжүүлэгч дотоодын болон гадаадын байгууллагууд хамтран хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, тухайн бүс нутгийн ус, намгархаг газар болон усны шувуудын одоогийн төлөв, ирээдүйн хандлагыг илэрхийлэх чиглэлтэй мэдээллийг олон улсын арга зүйгээр шинэчлэн цуглуулж, тулгарч буй бэрхшээлийг нарийвчлан тогтоох;
- Өгий, Буйр нуурын сав газрын агнуурын загасны нөөц, биологи –экологийн судалгаа, зохистой ашиглах, хамгаалах мониторингийн судалгааг гүйцэтгэх;

- Жуулчны баазуудын байрлалыг Монгол улсад мөрдөгдөж буй стандартыг баримтлан олгох, бэлчээрийг хувиартай ашиглуулах, бэлчээрийн талхагдлаас сэргийлэх;
- Зэрлэг амьтдын зурган индексийн судалгаа мэт орчин үеийн багаж ашиглан биологийн олон янз байдлын мониторингийн судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэх;
- Шувуу ажиглах цамхаг ба бусад байгууламжийг байгуулах;
- Дөргөн, Тайширын усан цахилгаан станцын ус намгархаг газрын ширгэлт, гол болон нуурын усны горим өөрчлөгдөх, түүнээс үүдэн гарах ус намгархаг газар болон усны шувуудад үзүүлэх сөрөг нөлөөг тооцсон байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг яаралтай давтан хийх;
- Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтын загас агнуурт хяналт тавих, загас идэшт усны шувуудын популяцийн төлөвийг үнэлэх замаар нуурын экосистемийг бүхэлд нь хянах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Монгол орны шувууны улаан данс болон хамгааллын төлөвлөгөө (2011)-д багтсан ховор шувуудын үржил, тоо толгой, нягтшил, нүүдлийн мониторингийг гүйцэтгэж, ус намгархаг газрын төлөв байдлыг экологийн индикатор бологч шувууны зүйлүүдийн тусламжтай тогтоож, мэдээ, баримтыг биологийн олон янз байдлын нэгдсэн мэдээллийн сан руу оруулах;
- Дөргөний усан цахилгаан станц төслийн хувьд байгаль, экологийн төрхийг хамгаалахын тулд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллаж, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх (Дэлхийн байгаль хамгаалах сан, 2003) шаардлагатай.

Г.Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр

- Биологийн болон ландшафтын олон янз байдлыг хамгаалах талаар ард иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн чадавхийг бэхжүүлэхэд анхаарах;
- Рамсарын жагсаалтад орсон нутгийн гарын авлагыг газар тус бүрээр гаргах, байгаль хамгаалах эко-клубын сурагч, гишүүдэд танилцуулах, хамтран ажиллах;
- “Ус намгархаг газар ба усны шувууд” нийтэд зориулсан сэтгүүл гаргах арга замаар ард иргэдэд ус намгархаг газар, усны шувууд, тэдгээрийг хамгаалахын ач холбогдлыг таниулах;
- “Рамсарын өдөр-Монгол” өдөрлөгийг хоёр жил тутамд зохион байгуулах;
- Усны болон усны эрэг орчмын ховор шувуудын үржлийн хэвийн байдлыг хангах, гуужиж буй шувуудыг амгалан тайван байлгах, нууруудын ширгэж буй шалтгааныг нутгийн иргэд, малчдад зөв ойлгуулахыг сурталчилсан гарын авлага, тараах материалыг бэлтгэх нь зүйтэй.

Д.Менежментийг сайжруулах чиглэлээр

- Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгааллын стратеги төлөвлөгөөнд Рамсарын Конвенц болон усны шувуудын тухай заалтыг шигтгэх замаар хамтын ажиллагааг сайжруулах;
- Конвенцийн Үндэсний зөвлөл үйл ажиллагаагаа тогтвортой явуулах санхүүгийн эх үүсвэртэй байх нөхцлийг бүрдүүлэх;
- Гадаад, дотоодын шувуу ажиглагч нарын шувуу ажиглах аялалыг шувуудад нөлөө багатай байхаар зохион байгуулахын тулд шувуу ажиглах байгууламж, цамхаг бэлтгэх хэрэгтэй байна.
- Дэлхийн Байгаль хамгаалах сангийн судалгааны үр дүнгээс дүгнэвэл Завхан голын сав газрын усан цахилгаан станц нь бизнесийн эрх ашиг болон бүрэн хүчин чадалдаа хүрэх зорилгоор сүүлийн хоёр жил далангаас доош Завхан голын олон жилийн дундаж урсацын 20 % хүртэлх усыг гаргахгүй байснаар өнөөдөр урсгалын доод чиглэл, улмаар цутгал нууруудын байдал хүндэрч, нутгийн ард иргэдийн бухимдлыг төрүүлж, улмаар төр засгийн ажил үйлчилгээнд чирэгдэл учруулж байна. Иймд усан цахилгаан станцын хүчин чадлыг хүлээлгүй, боломжтой эрчим хүчээ үйлдвэрлэж, мөн адил далангаас гаргах ёстой усаа тавьж Завхан голыг цаг алдалгүй сэлбэж, цаашдаа бүс нутгийн хөгжлийн эх үүсвэр болсон эрчим хүчний үйлдвэр ба амьдралын эх үүсвэр болсон усаа, усны нөөцийн нэгдсэн менежментийн хүрээнд байгаль орчинд халгүйгүйгээр, харилцан ойлголцон, уялдаатай ажиллаж, шийдэх шаардлагатай байна.

Е. Хурал, уулзалт, сургалтын чиглэлээр

- Рамсарын Конвенцийн чиглэлээрх Олон улсын уулзалт, сургалт, семинар зэрэгт төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл, мөн Рамсарын конвенцид бүртгэлтэй газар нутагт ажиллаж буй иргэн, судлаач, мэргэжилтнийг оролцуулах;
- Конвенцид бүртгэлтэй улсын тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны байцаагч болон бусад ажиллагсдын мэдлэг, боловсрол сул байгаа нь судлах, хамгаалах ажлыг сайжруулахад нөлөөлж байгааг харгалзан улсын хэмжээний нэгдсэн сургалтыг их, дээд сургуультай хамтран зохион байгуулах;
- Рамсарт орсон нутгийн байгаль хамгаалагч, судлаач, мэдээллийн төвийн ажилтан нараас хийж буй ажлынх талаар байнга мэдээлэл авах, улмаар үүнийг Рамсарын үндэсний мэдээллийн санд оруулах нь чухал байна.

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРСОН ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДЫН БАГА ХУРЛУУДААС ГАРСАН ШИЙДВЭРҮҮД БА ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ МОНГОЛ ОРОНД

Рамсарын жагсаалтад бүртгэлтэй, олон улсын хувьд ач холбогдол өндөртэй газар нутаг хэмээн тодорхойлогдсон эдгээр газарт конвенцид нэгдэн орсон Хэлэлцэн тохирогч Талуудын бага хурлаас гарсан шийдвэрүүд тусгалаа олж байх ёстой. Конвенцид нэгдэн орсон талууд уг шийдвэрийн дагуу ус намгархаг газрын судалгаа, хамгааллын чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулах шаардлагатай бөгөөд тухайн орны энэхүү олон улсын конвенцийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж буйг конвенцийн шийдвэрийн дагуу ажилласан байдлаас харж болно. Тиймээс ч бид энэ конвенцийн хүрээнд манай улсад хийж гүйцэтгэсэн ажлыг Монгол улс Конвенцид нэгдэж орсноос хойш болсон Хэлэлцэн тохирогч Талуудын Бага хурлын хуралдаанууд буюу 7 -10 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу тайлагнаж байна.

Конвенцийн Үндэсний зөвлөл 2011 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж, хуралдаанаар 2010-2013 онд хэрэгжүүлэх тус Зөвлөлийн стратеги, ажлын төлөвлөгөөг баталж, мөрдөн ажиллаж байна.

РАМСАРЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН СТРАТЕГИ, АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ: 2010-2013

Зорилго:

Рамсарын Конвенцийн Үндэсний зөвлөл нь Монгол орны ус намгархаг газар, түүний бүрэлдэхүүн болсон биологийн олон янз байдлын судалгаа, сургалт, сурталчилгаа, хамгааллыг улс орон даяар өрнүүлэх замаар дэлхий нийтийн хөгжлийн хандлагад нийцсэн үйл ажиллагааг явуулах үндсэн зорилготой.

Үндсэн зорилтууд:

Зорилт 1: Сургалт ба лекцүүд

Үр дүн

1. Ус намгархаг газар, түүнд шүтэж амьдардаг биологийн зүйлийн судалгаа, хамгааллын чиглэлээр лекц, семинарыг бага, дунд сургууль, оюутан залуучуудад зориулан зохион байгуулна.
2. Рамсарын конвенцийн чиглэлээрх олон улсын сургалт, судалгаанд идэвхтэй оролцож, хамтран ажиллана.

Зорилт 2: Мэргэжлийн төвшний судалгааны төслүүдийг гүйцэтгэх боломжийг хайх

Үр дүн

1. Ус намгархаг газар, түүнийг шүтэн амьдардаг, тоо толгой нь Монгол орон төдийгүй дэлхийн төвшинд ховордож буй зүйлүүдийн судалгааг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийг хайн олж, эхлүүлнэ.
2. Рамсарт бүртгэлтэй Хурх, Хүйтэн голын хөндийн талаарх судалгаа, сурталчилгааг бусад газарт загвар болох хэмжээнд гүйцэтгэнэ.

3. Рамсарын конвенцийн чиглэлээр Монгол улсад хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаатай танилцаж, хамтран ажиллана.

Зорилт 3: Ном, гарын авлага, тодорхойлох бичгүүдийг хэвлэх, сурталчилгаа

Үр дүн

1. Рамсарын конвенцийн тухай ерөнхий ойлголтыг нийтэд өгч чадах гарын авлага хэвлэнэ.
2. Үндэсний хэмжээнд одоогоор Рамсарын жагсаалтад бүртгэлтэй газар нутгуудын талаарх цуврал гарын авлага бэлтгэж, хэвлэнэ.
3. Монгол улсын Рамсарын жагсаалтад бүртгэлтэй газар нутгуудыг бүртгэснээс хойш өнөөдрийг хүртэл явуулсан үйл ажиллагаа, хамгааллын үр дүнгийн үнэлгээг хийнэ.
4. “Дэлхийн ус намгархаг газрын өдөр”-ийг Монгол оронд жил бүр тэмдэглэнэ.

Зорилт 4: Мэдээллийн сан үүсгэх, баяжуулах, сайжруулах

Үр дүн

1. Рамсарт бүртгэлтэй газрын мэдээллийг нэгтгэх, мэдээллийн санг үүсгэнэ.
2. Дээрх мэдээллийн санг бусад мэдээллийн сантай холбох, интернетийн сүлжээнд байршуулах замаар нийтэд хүртээмжтэй болгоно.
3. Рамсарын конвенци, түүнтэй холбоотой олон улсын хэмжээний баримт, актыг БОАЖЯ, их сургуулиудын интернэт сүлжээнд байршуулах замаар энэ конвенцийн үйл ажиллагааг сурталчилна.
4. Үндэсний зөвлөлийн стратеги болон зөвлөлийн гишүүдийн талаарх мэдээллийг интернэтэд байршуулна.

КОНВЕНЦИЙН ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 7-Р ХУРАЛДААН

“Хүмүүс ба ус намгархаг газар: амин холбоо”

“Хүмүүс ба Ус намгархаг газар: амин холбоо” уриан дор Талуудын Бага хурлын 7-р хуралдаан Коста Рика улсын Сан Хосе хотод 1999 оны 5-р сарын 10-18-нд зохион байгуулагджээ. Манай улс энэ хуралд албан ёсоор оролцсон бөгөөд хурлын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж эхлэв.

Шийдвэр	Шийдвэрийн ерөнхий агуулга	Биелэлт
Шийдвэр VII.2	Конвенцийн шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн ба үйл ажиллагааны арга замууд	<ul style="list-style-type: none"> Энэ шийдвэрийн дагуу бие даасан тодорхой ажил хийгдээгүй нь энэ ажлын хэсгийг манай улсад байгуулаагүйтэй холбоотой.
Шийдвэр VII.4	Бусад конвенциудын түншлэл ба хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Биологийн олон янз байдлын конвенцитай тодорхой газар нутгийн хүрээнд судалгаа, хамгааллын ажлыг хамтран зохион байгуулж байв. Тухайлбал, Монгол Дагуур, Өгий нуур, Тэрхийн Цагаан нуур, Нууруудын хөндийн нуурууд (Бөөн цагаан, Таацын цагаан, Адгийн цагаан, Орог нуур), Хар-Ус, Айраг нуурын биологийн олон байдлын судалгаа, хамгааллын ажлыг дээрх хоёр конвенцийн хүрээнд хийж гүйцэтгэж байна.
Шийдвэр VII.5	Ус намгархаг газрын хамгаалал ба хэрэглээ, түүний ирээдүйн үйл ажиллагаанд зориулсан конвенцийн жижиг тэтгэлгийн сангийн үнэлгээ	<ul style="list-style-type: none"> Энэ сангаас дэмжлэг хүссэн төсөл, хөтөлбөрийг боловсруулаагүй тул энэ сангаас санхүүгийн ямар нэг дэмжлэг аваагүй.
Шийдвэр VII.6	Ус намгархаг газрын үндэсний хэмжээний бодлогыг хэрэгжүүлэх болон сайжруулах арга	<ul style="list-style-type: none"> Монгол улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн

<p>Шийдвэр VII.7</p> <p>Шийдвэр VII.10</p>	<p>замууд</p> <p>Ус намгархаг газрыг ашиглах ба хамгаалах үйл ажиллагааг сурталчлах байгууллага болон хуулийг нягтлан үзэх арга замууд</p> <p>Ус намгархаг газрын эрсдлийн үнэлгээний хүрээ</p>	<p>тухай хууль (1995), Усны тухай хууль (1995), Ус ашигласны төлбөрийн тухай хууль (1995), Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль (1995) нь ус намгархаг газрыг зөв зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд онцгой ач холбогдолтой байдаг.</p> <ul style="list-style-type: none"> Ус намгархаг газрын эрсдлийн үнэлгээ Олон улсын стандартын дагуу хийгдэж байсангүй.
<p>Шийдвэр VII.11</p> <p>Шийдвэр VII.12</p>	<p>Олон улсын хувьд ач холбогдол бүхий ус намгархаг газрын жагсаалтыг цаашид сайжруулах стратегийн хүрээ ба арга замууд</p> <p>Олон улсын хувьд ач холбогдол бүхий ус намгархаг газрууд: албан ёсны тодорхойлолт, хамгааллын статус, менежментийн төлөвлөгөө, ялангуяа тодорхой ус намгархаг газар нутгийн өнөөгийн байдал</p>	<ul style="list-style-type: none"> Монгол Дагуур, Өгий нуур, Тэрхийн Цагаан нуур, Нууруудын хөндийн нуурууд (Бөөн цагаан, Таацын цагаан, Адгийн цагаан, Орог нуур), Хар-Ус, Айраг нуурыг Конвенцийн жагсаалтанд оруулах үндэслэл, шалгуурыг ажлын хэсэг баталгаажуулан албан ёсоор бүртгүүлсэн (өмнө дурдсан жагсаалтад буй нууруудын мэдээллийг үзнэ үү). Жагсаалтад орсон нутаг бүрээр гаргасан үйл ажиллагаа болон хамгааллын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулаагүй ба энэ ажил зөвшилцлийн төвшинд байна.
<p>Шийдвэр VII.14</p>	<p>Харь зүйл ба ус намгархаг газар</p>	<ul style="list-style-type: none"> Харь зүйлийн ус намгархаг газарт нөлөөлөх байдал, харь зүйлийн судалгааны ажил энэ конвенцийн хүрээнд хангалттай хийгдээгүй. Заарт харх буюу ондатр, усны булга зэрэг зүйлийг гаршуулах, ус намгархаг газарт нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг хийх ажлыг Ховд аймгийн Хар-Ус нуур (Мөнхтогтох ба Шар, 2006) болон Сэлэнгийн савд зохион байгуулжээ.

Шийдвэр VII.16	Рамсарын конвенц ба нөлөөллийн үнэлгээ: Стратеги, хүрээлэн буй орчин ба нийгмийн зүгээс	<ul style="list-style-type: none"> • Энэ шийдвэрийн дагуу энэ конвенцийн хүрээнд манай улсад зохион байгуулсан ажил хомс байна.
Шийдвэр VII.17	Ус намгархаг газрыг дахин сэргээх, ус намгархаг газрыг ашиглах болон хамгаалах	<ul style="list-style-type: none"> • Байгалийн ус намгархаг газрыг дахин сэргээх, тогтвортой ашиглах чиглэлийн судалгаа, хамгааллын ажлыг энэхүү конвенцийн хүрээнд зохион байгуулаагүй.
Шийдвэр VII.19	Конвенцийн хүрээнд олон улсын хамтын ажиллагааны арга замууд	<ul style="list-style-type: none"> • Японы Кеиданрен байгаль хамгаалах сан болон Японы хүрээлэн буй орчны агентлаг, мөн Монголын Хөгжил ба хүрээлэн буй орчин төрийн бус байгууллага хамтран ивээн тэтгэсэн Монгол болон Зүүн Хойд Азийн Ус намгархаг газрын хамгаалал Олон улсын бага хурлыг 1997 оны 9-р сарын 16-19-д Улаанбаатар хотноо Байгаль орчны яам, Wetlands International Asia Pacific байгууллага зохион байгуулж, манай улсын ус намгархаг газар болон усны шувуудын одоогийн төлөв байдал, цаашид хэрхэн ажиллах тухай авч хэлэлцжээ.
Шийдвэр VII.25	Ус намгархаг газрын хүрээлэн буй орчны чанарын хэмжилт	<ul style="list-style-type: none"> • Энэ шийдвэрийн дагуу Конвенцийн хүрээнд манай улсад зохион байгуулсан ажил хомс байна.



Ус намгархаг газрын хаталт

Булган аймгийн Баян нуурын ус намгархаг газар нь Азийн цууцил мэт ховор шувуудын үржихэд нэн тохиромжтой орчин байв.

2006 оны 6-р сар.

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

Уур амьсгалын өөрчлөлт, малын тоо олширсон зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр Баян нуурын ус намгархаг газар хатаж байна.

2011 оны 6-р сар.

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

КОНВЕНЦИЙН ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 8-Р ХУРАЛДААН

“Ус намгархаг газар: ус, амьдрал ба соёл”

“Ус намгархаг газар: ус, амьдрал ба соёл” уриан дор Талуудын Бага хурлын 8-р хуралдаан Испани улсын Валенсия хотод 2002 оны 11-р сарын 18-26-нд зохион байгуулагджээ.

Хурлын шийдвэрийн дагуу хийсэн ажлыг дараах байдлаар сийрүүлэн бичив.

Шийдвэр	Шийдвэрийн ерөнхий агуулга	Биелэлт
Шийдвэр VIII.1	Ус намгархаг газрын экологийн үйл явцыг тогтворжуулах усны хуваарилалт болон менежментийн арга замууд	<ul style="list-style-type: none"> Усны чиглэлээр ажилладаг төрийн ба төрийн бус байгууллагын үйл ажиллагааны чиглэл, хамтын ажиллагааны цар хүрээ хумигдмал тул тус тусдаа ажил хийж ирсэн.
Шийдвэр VIII.3	Уур амьсгалын өөрчлөлт ба ус намгархаг газар: нөлөөлөл, зохилдолгоо ба нөлөөллийг бууруулах	<ul style="list-style-type: none"> Ууур амьсгалын өөрчлөлтийн ус намгархаг газарт үзүүлсэн нөлөөллийг Биологийн олон янз байдал, Цөлжилт, Тусгай хамгаалалттай газар нутгийн хүрээнд хийж, үр дүнг хамтран хүртэж байна.
Шийдвэр VIII.9	Хүрээлэн буй орчны нөлөөллийн үнэлгээг хуульчлахад биологийн олон янз байдлын тухай асуудлуудтай холбох арга замууд/ Биологийн олон янз байдлын конвенциас гаргасан хүрээлэн буй орчны үнэлгээний стратегийг хэрхэн хэрэгжүүлэх болон тэдгээрийн Рамсарын конвенцтай холбоотой болох	<ul style="list-style-type: none"> Рамсарын болон Биологийн олон янз байдлын конвенцийн хамтын ажиллагаа сул байгаа бөгөөд цаашид тус хоёр конвенци нь тодорхой чиглэлээр хамтарсан ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Жишээлбэл, уг хоёр конвенцийн бүрэлдэхүүнд “Харь зүйл” гэсэн заалт байдаг ба хамтран энэ асуудлыг шийдвэрлэх нэн шаардлагатай.
Шийдвэр VIII.13	Олон улсын хувьд ач холбогдолтой ус намгархаг газрын мэдээллийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> Манай орны Рамсарт бүртгэлтэй газар нутагт хийсэн судалгаа, хамгаалал, бодлогын ажлууд нь шинэчлэгдээгүй тул мэдээ, баримт нь анх шалгуурыг хангасан байдлаар байна. Иймээс

		<p>нийт 11 газарт судалгаа, хамгааллын нэгдсэн протоколын тусламжтай мэдээлэл цуглуулж, улмаар энэ мэдээлэл дээрээ үндэслэсэн суурь мэдээллийн сан байгуулах шаардлагатай талаар талууд харилцан ярилцаж байна.</p>
Шийдвэр VIII.16	Ус намгархаг газрыг сэргээх зарчим ба арга замууд	<ul style="list-style-type: none"> • Нууруудын хөндийн нуур тухайлбал Орог мэт ширгэсэн нууруудын ширгэсэн шалтгаан, түүнийг сэргээх боломж буй эсэхийг нягтлан үзэх ажлыг зохион байгуулаагүй.
Шийдвэр VIII.18	Харь зүйл ба ус намгархаг газар	<ul style="list-style-type: none"> • Заарт харх буюу ондатр, усны булга зэрэг зүйлийг гаршуулах, ус намгархаг газарт нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг хийх ажлыг Ховд аймгийн Хар-Ус нуур (Мөнхтогтох ба Шар, 2006) болон Сэлэнгийн савд зохион байгуулжээ.
Шийдвэр VIII.25	Рамсарын стратегийн төлөвлөгөө (2003-2008)	<ul style="list-style-type: none"> • Үндэсний зөвлөл манай улсын стратегийн төлөвлөгөөг энэ хугацаанд хийж боловсруулаагүй.
Шийдвэр VIII.28	Конвенцийн шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн ба үйл ажиллагааны арга замууд	<ul style="list-style-type: none"> • Конвенцийн шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсгийг хариуцсан хүн конвенцийн үндэсний стратеги төлөвлөгөө, конвенцийн жагсаалтад багтсан ус намгархаг газар болон усны шувуудын тухай мэдээ, баримтыг нэгтгээгүй.
Шийдвэр VIII.29	Ус намгархаг газрын хамгаалал ба хэрэглээнд зориулсан Конвенцийн тэтгэлгийн сан болон Рамсар хандивын сангийн үнэлгээ	<ul style="list-style-type: none"> • Энэ санд хандаж санхүүжилт олж ирээгүй.
Шийдвэр VIII.30	Конвенцийг ирээдүйд хэрэгжүүлэх талаарх бүс нутгийн санаачилгууд	<ul style="list-style-type: none"> • БОЯ-ны туслалцаатай Увс нуурын ай савын дархан цаазат газрыг Шим мандлын нөөц газрын сүлжээнд 1998 онд хамруулсны дээр Дэлхийн соёл болон байгалийн өвийн бүртгэлд 2003 онд оруулав.

Шийдвэр VIII.31	Мэдээлэл харилцаа, боловсрол, сургалт сурталчилгааны хөтөлбөр (2003-2008)	<ul style="list-style-type: none"> Байгаль орчны яам, Шинжлэх ухааны академи, Дорнод аймгийн тамгын газар, Дархан цаазат газрын захиргаа, Олон улсын байгууллага хамтран 2003 оны 08- сарын 26-31-д Монгол Дагуурын ДЦГ-ын Дөрөө нууранд "Зүүн хойт Азийн тогорууны сүлжээ нутаг дахь сургалт ба менежмент сэдэвт олон улсын сургалтыг зохион байгуулав.
Шийдвэр VIII.34	Хөдөө аж ахуй, ус намгархаг газар болон усны нөөцийн менежмент	<ul style="list-style-type: none"> Энэ чиглэлээр Рамсарын конвенцийн хүрээнд манай оронд хийсэн ажил харьцангуй бага ба харин бусад конвенц, төслийн хүрээнд тодорхой ажил хийгджээ.
Шийдвэр VIII.35	Ус намгархаг газрын экосистемд байгалийн гамшиг ялангуяа хуурайшлын нөлөөлөл	
Шийдвэр VIII.37	Ази-Номхон Далайн бүс нутаг дахь нүүдлийн шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах Олон улсын хамтын ажиллагаа	<ul style="list-style-type: none"> Рамсарын конвенцийн жагсаалтад орсон хөрш зэргэлдээ орнуудын хил дамжин оршдог Монгол Дагуурын ДЦГ-ыг ОХУ-ын Даурын ДЦГ, БНХАУ-ын Далай нуурын ДЦГ-тай хамтран хамгаалах ажлыг хэрэгжүүлж байна.
Шийдвэр VIII.38	Усны шувуудын популяцийн үнэлгээ ба Олон улсын чухал ач холбогдолтой ус намгархаг газрыг тодорхойлох ба сонгох	<ul style="list-style-type: none"> ШУА-ийн Биологийн хүрээлэн, Дорнодын ТХГ-уудын Дорнод хамгаалалтын захиргаа, Дэлхийн Байгаль орчны Японы итгэмжлэгдсэн байгууллага хамтран Монгол Дагуурын дархан цаазат газар, түүний орчмын ус намгийн шувууд, Монгол Дагуурын ДЦГ-ын ховор шувуудын талаарх тараах материал, гарын авлагыг 2004 онд хэвлүүлэв (Цэвээнмядаг, 2004).
Шийдвэр VIII.41	Баруун ба Төв Азийн Ус намгархаг газрын сургалт, судалгааны бүс нутгийн төвийг байгуулах	<ul style="list-style-type: none"> Сургалт, судалгааны төвийг байгуулаагүй.



Ширгэж хатсан Орог нуур
2006 оны 6-р сар.

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

КОНВЕНЦИЙН ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 9-Р ХУРАЛДААН

“Ус намгархаг газар ба ус: амьдралыг тэтгэгч ба амьжиргаа”

“Ус намгархаг газар ба ус: амьдралыг тэтгэгч ба амьжиргаа” урин дор Талуудын Бага хурлын 9-р хуралдаан Уганда улсын Кампала хотод 2005 оны 11-р сарын 8-15-нд зохион байгуулагджээ.

Бага хурлаас гарсан шийдвэр болон шийдвэрийн биелэлтийг дараах хүснэгтээс уншина уу.

Шийдвэр	Шийдвэрийн ерөнхий агуулга	Биелэлт
Шийдвэр IX.1, Хавсралт B	Олон улсын ач холбогдолтой Ус намгархаг газрын жагсаалтыг ирээдүйд сайжруулах стратегийн хүрээ ба арга замуудыг хянах	<ul style="list-style-type: none"> • Конвенцийн жагсаалтанд багтсан газрын тухай мэдээллийг нэгтгэх, ус намгархаг газар болон усны шувуудын тухай мэдээ, баримтыг нэгтгэх, шинэчлэх талаарх ажлууд ярилцлагын төвшинд байна.
Шийдвэр IX.1, Хавсралт Ci	Голын сав газрын менежмент: жишээлсэн судалгааны анализын нэмэлт арга замууд ба хүрээ	<ul style="list-style-type: none"> • Өгий нуур болон Орхон голын сав газар орчмын ус зүй, экологийн цогц судалгааг 2005-2006 онд гидрологи, усны чанар, усны шавьж, загас, шувуу, хөхтөн, (2 нутагтан, мөлхөгч хамт), ургамал, фито планктон, зоо планктон гэсэн 9 чиглэлээр хийсэн. Судалгаагаар Өгий нуур, Орхон голын сав газарт 266 зүйл ургамал, 128 зүйл шувуу, 14 зүйл загас, 19 зүйл хөхтөн, 1 зүйл 2 нутагтан, 3 зүйл мөлхөгч бүртгэгджээ. • Дэлхийн Байгаль хамгаалах сангийн судалгааны үр дүнгээс дүгнэвэл Завхан голын сав газрын усан цахилгаан станц нь бизнесийн эрх ашиг болон бүрэн хүчин чадалдаа хүрэх зорилгоор сүүлийн хоёр жил далангаас доош Завхан голын олон жилийн дундаж урсацын 20 хүртэлх усыг гаргахгүй байснаар өнөөдөр урсгалын доод чиглэл, улмаар цутгал нууруудын байдал хүндэрч, нутгийн ард иргэдийн

<p>Шийдвэр IX.1, Хавсралт Cii</p>	<p>Ус намгархаг газрын экологийн чанарыг сайжруулах гүний усны менежментийн арга замууд</p>	<p>бухимдлыг төрүүлж, улмаар төр засгийн ажил үйлчилгээнд чирэгдэл учруулж байна. Иймд усан цахилгаан станцийн хүчин чадлыг хүлээлгүй, боломжтой эрчим хүчээ үйлдвэрлэж, мөн адил далангаас гаргах ёстой усаа тавьж Завхан голыг цаг алдалгүй сэлбэж, цаашдаа бүс нутгийн хөгжлийн эх үүсвэр болсон эрчим хүчний үйлдвэр ба амьдралын эх үүсвэр болсон усаа, усны нөөцийн нэгдсэн менежментийн хүрээнд байгаль орчинд халгүйгүйгээр, харилцан ойлголцон, уялдаатай ажиллаж, шийдэх шаардлагатай байна.</p> <ul style="list-style-type: none"> • Дөргөний усан цахилгаан станц төслийн хувьд байгаль, экологийн төрхийг хамгаалахын тулд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллаж, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх (Дэлхийн байгаль хамгаалах сан, 2003) шаардлагатай. • Рамсарын конвенцийн хүрээнд энэ чиглэлээр манай оронд хийсэн ажил харьцангуй бага ба харин бусад конвенц, төслийн хүрээнд энэ чиглэлийн ажил тодорхой төвшинд хийгджээ.
<p>Шийдвэр IX.3</p>	<p>Устай холбоотой олон талт үйл ажиллагааг Рамсарын конвенцтой холбох</p>	<ul style="list-style-type: none"> • Бодлогын хувьд энэ асуудлыг зангидан ажиллах шаардлагатай байгааг конвенцийн үндэсний зөвлөл, Засгийн газрын төв байгууллага анхаарах шаардлагатай. Энэ чиглэлийн ажил ярилцлагын төвшинд байна.

Шийдвэр IX.4	Рамсарын конвенц ба загасны нөөцийн хамгаалал, бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон тогтвортой ашиглалт	<ul style="list-style-type: none"> • Рамсарын конвенцийн хүрээнд энэ чиглэлээр манай оронд хийсэн ажил харьцангуй бага.
Шийдвэр IX.6 Шийдвэр IX.7	Рамсарын жагсаалтанд орсон газрууд бүхэлдээ, эсвэл зарим хэсэг нь Рамсарын шалгууртай тохирохоо больсныг харуулах арга замууд Рамсарын конвенцийн хүрээ дэх бүс нутгийн санаачилгууд	<ul style="list-style-type: none"> • Говийн Нууруудын хөндийн зарим нуурууд ширгэсэн ба энэ шийдвэрийн хүрээнд ажил зохион байгуулагдаагүй. • МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Хустайн БЦГ хамтран Рамсарын жагсаалтанд багтсан зарим нуурууд, жишээлбэл Хар-Ус нуурт өвөлжиж буй усны шувуудын тооллого хийж, судалгааны мэдээ, баримтыг нэгдсэн мэдээллийн санд оруулан мэдээ, баримтыг нэгтгэж, олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлж, хэвлүүлжээ (Gombobaatar, 2004; www.mos.mn). • БОАЖЯ, BirdLife International, World Bank, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв хамтран 2007-2009 онд Монгол орны шувуудад чухал газрууд бүтээлийг хэвлүүлэв (http://wscc.org.mn/iba.html).
Шийдвэр IX.13 Шийдвэр IX.15	Конвенцийн жижиг тэтгэлгийн сангийн эх үүсвэр болсон Рамсарын Хандивын сангийн үнэлгээ Олон улсын хувьд ач холбогдолтой ус намгархаг газрын статус	<ul style="list-style-type: none"> • Конвенцийн жагсаалтад орсон газар нутаг болон усны шувуудын тухай мэдээ, баримтыг нэгтгэх, шинэчлэх, мэдээллийн сан үүсгэх, газар нутгийн олон улсын статусыг тогтоох ажилд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг энэ сангаас олж авах шаардлагатай байна. • Конвенцийн жагсаалтад багтсан газар нутаг болон усны шувуудын тухай мэдээ, баримтыг нэгтгэх, шинэчлэх замаар статусыг тогтоох ажил хангалтгүй хийгдэж байна.

Шийдвэр IX.18	Мэдээлэл харилцаа, боловсрол, сургалт сурталчилгааны хөтөлбөрийн хяналтын хэсэг байгуулах	<ul style="list-style-type: none"> • Рамсарын конвенцийн шугамаар 2006 онд 5 хүн Япон улсад Рамсарын конвенцийн мэдээлэл харилцаа холбоо, боловсрол, олон нийтийн сурталчилгааны асуудал хариуцсан үндэсний зохицуулагч нарын уулзалтанд оролцов. • Биологийн хүрээлэн, Шувуу судлалын сан, мөн Өгий нуурын экосистемийг хамгаалах ЖАИКА-ийн төслөөр Өгий нуур орчим нутгийн шувууд өгүүлэл, гарын авлагыг хэвлүүлж, энэ нуурыг цаашид хамгаалах, зүй зохистой ашиглах менежмент боловсруулах тулгуур материалыг бүрдүүлэв (Цэвээнмядаг ба Болд, 2005; Өгий нуурын экосистемийг хамгаалах төслийн тайлан, 2005 ба 2006). • Биологийн хүрээлэн, Шувуу судлалын сан Биологийн хүрээлэн, Монгол-Оросын хамтарсан экспедици Бөөнцагаан нуурт нийт 6 удаагийн хайгуул судалгаа хийж, үр дүнгээр нь 161 зүйл шувуудын зүйлийн бүрдэл, оршин амьдрах хэлбэр, зарим ховор шувуудын биологи, экологи, тоо толгойн талаар өгүүлэл хэвлүүлэв (Болд, 2005). • МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, Английн шувуу хамгаалах вангийн нийгэмлэг /RSPB/ хамтран Рамсарт орсон дорнод бүс нутгийн нууруудыг хамруулан Дорнод Монголын шувуудад чухал газрыг тодорхойлох Олон улсын хамтарсан судалгааг 2004 онд хэрэгжүүлж, Монгол орны дорнод бүс нутгийн рамсарт орсон нуурууд, ялангуяа Буйр нуур нь нүүдлийн шувуудын үрждэг, дайрч өнгөрдөг шувуудын чухал нутаг мөн болохыг тогтоов. Үндэсний хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутагт оруулах замаар хамгаалах
---------------	---	--

		<p>шаардлагатайг мөн тодорхойлов. Судалгааны ажлын явцад Монгол оронд өмнө нь цөөн бүртгэгдсэн шувуудын талаарх баялаг мэдээ, баримтыг цуглуулав (Badley <i>et al.</i>, 2005; www.mos.mn).</p> <ul style="list-style-type: none"> • МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэг нь Олон улсын Working Group International Waterbird & Wetland Research (WIWO) байгууллагтай хамтран 2005 онд Монгол орны дорнод бүс нутгийн нуурууд, тухайлбал, Монгол Дагуурын дархан цаазат газрын зарим нуурууд Азийн сүвээцагаан (<i>Pluvialis fulva</i>) шувууны хувьд онцгой ач холбогдолтой болохыг тогтоож, нүүдлийн үе дэх хооллох зан төрхийн судалгааг гүйцэтгэв (Jeroen <i>et al.</i>, 2005; www.mos.mn). • Айраг нуурын шувуудын судалгааг нэгтгэн, Айраг нуур ба түүний орчим нутгийн шувууны тойм бүтээлийг хэвлүүлэв (Болдбаатар, 2007). • ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв, Солонгосын Үндэсний шинжлэх ухааны музей хамтран Буйр нуурын Хошуу галуу болон усны шувууны судалгааг 2006-2008 онд гүйцэтгэв.
Шийдвэр IX.21	Ус намгархаг газрын соёлын үнэ цэнийг харгалзан үзэх	<ul style="list-style-type: none"> • Энэ чиглэлээр конвенцийн зүгээс ажил хангалттай зохион байгуулаагүй.
Шийдвэр IX.22	Рамсарын газрууд ба тусгай хамгаалалттай газар нутаг	<ul style="list-style-type: none"> • УИХ-ын 2004 оны 22-р тогтоолоор Дарьгангын Байгалийн дурсгалт газрыг БЦГ болгон хамгаалалтын статусыг дээшлүүлэв (УИХ-ын 2004 оны 4-р сарын 29-ны 22-р тогтоол).
Шийдвэр IX.23	Хоруу чанар өндөртэй шувууны ханиад,	<ul style="list-style-type: none"> • НҮБ-ын Шувууны томууны төсөл, Улсын мал эмнэлгийн


түүний ус намгархаг газар болон усны шувуудын хамгаалал, ашиглалд нөлөөлөх байдал, үр дагавар

төв лаборатори, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв хамтран 2007 онд Ганга нуур, түүний орчмын ус, намгархаг газарт зүүн 3 аймгийн байгаль орчин, мал эмнэлгийн ажилтнуудад шувууны томуугийн талаар сургалт, сурталчилгааны ажлыг хийв.



Сансарын дамжуулагчтай Гангар хун (*Cygnus cygnus*)

Гэрэл зургийг С.Гомбобаатар©



Баянхонгор аймгийн Бөөн цагаан нуур болон
Өвөрхангай аймгийн Сангийн далай нуурт үржсэн
Гангар хун БНХАУ хүрч өвөлжив

КОНВЕНЦИЙН ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУДЫН БАГА ХУРЛЫН 10-Р ХУРАЛДААН

“Эрүүл ус намгархаг газар ба эрүүл хүн”

“Эрүүл ус намгархаг газар ба эрүүл хүн” уриан дор Талуудын Бага хурлын 10-р хуралдаан Өмнөд Солонгос улсын Чангвон хотод 2008 оны 10-р сарын 28-наас 11-р сарын 4-нд зохион байгуулагджээ.

Талуудын бага хурлаас гарсан шийдвэр ба биелэлтийн талаарх ерөнхий мэдээллийг дараах хүснэгтээс авна уу.

Шийдвэр дугаар	Шийдвэрийн ерөнхий агуулга	Биелэлт
Шийдвэр Х.1	Стратегийн төлөвлөгөө 2009-2015	<ul style="list-style-type: none"> • Конвенцийн Үндэсний зөвлөл 2011 оны 4 сарын 29-нд хуралдаж, 2010-2013 онд хэрэгжүүлэх тус Зөвлөлийн стратеги, ажлын төлөвлөгөөг баталж, мөрдөн ажиллаж байна.
Шийдвэр Х.6	Бүс нутгийн санаачилгууд 2009-2012	<ul style="list-style-type: none"> • Дэлхийн Банк, Нидерландын вант улс, Лондоны амьтан судлалын нийгэмлэг, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Степ форвард, БОАЖЯ, МУИС, ШУА болон бусад байгууллагууд хамтран Монгол орны шувууны улаан данс бүтээлийг 2011 онд хэвлүүлэв. Бүтээлд Монгол орны шувуудын амьдрах орчин, ялангуяа ус намгархаг газраар тархах онцлог, зүйлийн баялаг зэргийг тусгав. Мөн хамгаалах шаардлагатай зүйл, газар нутгийн тухай энэ бүтээлд бичжээ (Gombobaatar, Monks <i>et al.</i>, 2011; www.mos.mn). Мөн энэ ажлын хүрээнд “Монгол орны шувууны хамгааллын төлөвлөгөө” бүтээлийг хэвлүүлж, Монгол орны ховор шувуудын амьдрах орчин, ялангуяа ус намгархаг газраар тархах онцлог, зүйлийн баялаг зэргийг тусгажээ (Gombobaatar <i>et al.</i>, 2011; www.mos.mn). • Зүүн Ази АвстралАзийн шувуудын нүүдлийн замын хамтын ажиллагаа бүс нутгийн санаачлагыг дэмжиж Монгол улс уг

		<p>санаачлагад нэгдсэн бөгөөд одоогоор Хурх Хүйтний хөндий, Өгий нуур гэсэн 2 газрыг энэхүү санаачлагад хамруулаад байна.</p>
Шийдвэр Х.8	Мэдээлэл харилцаа, боловсрол, сургалт сурталчилгааны хөтөлбөр 2009-2015	<ul style="list-style-type: none"> • Рамсарын конвенцийн шугамаар БОАЖЯ-ны дэмжлэгтэйгээр 2010 оны 4 сарын 19-22-нд Тайланд улсад зохион байгуулагдсан Рамсарын конвенцийн мэдээлэл, харилцаа холбоо, боловсрол, олон нийтийн сурталчилгааны асуудал хариуцсан үндэсний зохицуулагч нарын уулзалт болон 2011 оны 5 сарын 17-ноос 7 сарын 6-нд Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг (ЖАИКА)-аас зохион байгуулсан сургалтад БОАЖЯ-аас 3 хүн оролцов. • Монгол Улсын нэгдэн орсон байгаль орчны чиглэлийн 11 конвенци, 3 протоколын эх бичвэрүүдийн монгол орчуулгыг Гадаад харилцааны яамаар хянан баталгаажуулж, “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2010 оны 3 сарын 31-ний өдрийн №9-д албан ёсоор хэвлүүлэн, салбарын холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөв. Рамсарын конвенцийн танилцуулга, Талуудын бага хурлаас гаргасан Чангвоны тунхаглал, бүртгэлтэй газруудын тодорхойлолтыг англи, монгол хэлээр хэвлүүлэн олон нийтийн хүртээл болголоо. • БОАЖЯ болон Архангай аймгийн Өгий нуур сумын захиргаа, Японы ЖАИКА байгууллага 2009 оноос хамтран Өгий нуурын мэдээлэл, сургалтын төв байгуулж, орон тооны захиргаа бий болгожээ. • ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв, Хорго-Тэрхийн Цагаан нуурын БЦГ-т Рамсарт бүртгэлтэй Тэрхийн Цагаан нуурын усны шувуу, экосистемийг хамгаалах зорилгоор сурталчилгааны зурагт


		<p>хуудас хийж орон нутгийн удирдлага, хамгаалалтын захиргаанд өгсөн ба мөн нутгийн иргэдэд ухуулга сурталчилгааны ажил хийв (Н.Цэвээнмядаг ам мэдээ).</p> <ul style="list-style-type: none"> • Монголын шувуу судлалын нийгэмлэг, Монгол улсын их сургууль, БОАЖЯ хамтран “Хурх, Хүйтэний хөндийн шувууд” гарын авлагыг 2011 оны 9-11-р сард хэвлэн, тус нутгийн иргэдэд тараасан нь шувуу сонирхох, судлах, хамгаалах ажилд чухал ач холбогдолтой байв (Гомбобаатар ба Жаргалсайхан, 2011). • МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Дорнын нүүдэлчид ХХК, ХААИС хамтран Дэлхийн нүүдлийн шувууны өдрийг 2011 оноос эхлэн амжилттай зохион байгуулж байгаа бөгөөд жил бүрийн үйл ажиллагаанд төрийн ба төрийн бус байгууллага, хувь хүн, хувийн компанийн нийт 30 орчим хүн оролцож байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.mos.mn хаягаас авна уу.
Шийдвэр Х.10	Конвенцийн хэрэгжилтийн шинжлэх ухааны ба техникийн асуудлууд	<ul style="list-style-type: none"> • Увс, Хяргас, Айраг, Хар-Ус, Хар, Дөргөн нуурууд оршдог баруун бүс нутагт Дэлхийн байгаль хамгаалах сангийн техникийн туслалцаатай бүс нутгийн Биологийн төрөл зүйл болон усны экосистем, нөөц баялгийг зүй зохистой ашиглан хамгаалах төсөл, мөн Дорнод Монголын Улсын тусгай хамгаалалттай газруудад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийг хэрэгжүүлэв.
Шийдвэр Х.11	Байгаль орчны олон талт гэрээ хэлэлцээрүүд, бусад байгууллагын хамтын ажиллагаа болон уялдаа холбоо	<ul style="list-style-type: none"> • 2011 оны 5-р сард БОАЖЯ, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Зүүн Ази, Авсрали Азийн нүүдлийн замын сүлжээ олон улсын байгууллагын дарга Рожер Женш, судалгаа хариуцсан менежер Чанг Ёнг Чой нартай ажлын уулзалт хийж, Хурх-Хүйтэний хөндийн шувууд гарын

		авлага бичих санхүү, Эргийн шувууны олон улсын хурлыг Монголд зохион байгуулах ажил, цаашид хамтран ажиллах ажлуудын тухай хэлэлцэв (Д.Батболд, С.Гомбобаатар ам мэдээ).
Шийдвэр Х.13	Рамсарын газруудын нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> • Рамсарын жагсаалтад орсон газар нутгуудын одоогийн байдал болон ирээдүйн хандлагыг тодорхойлох чиглэлээр дагнасан ажил одоо хир зохион байгуулагдаагүй.
Шийдвэр Х.14	Рамсарын мэдээллийн сан ба хэрэгцээ шаардлага	<ul style="list-style-type: none"> • Дэлхийн Банк, Недерландын Вант улсын дэмжлэг, санхүүжилт, Лондоны амьтан судлалын нийгэмлэг, Монголын шувуу судлалын нийгэмлэг болон МУИС хамтран Монгол орны шувуудын үндэсний мэдээллийн санг Олон улсын байгаль хамгаалах холбооны стандартын дагуу байгуулсан бөгөөд энд Монгол орны Рамсарт орсон бүхий л нутагт тохиолдох бүх зүйл шувуудын дэлгэрэнгүй мэдээлэл, мэдээ, баримтыг тусгасан үндэсний анхны томоохон ажил боллоо (Gombobaatar, Monks <i>et al.</i>, 2011; www.mos.mn). • НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагын Зэрлэг амьтны эрүүл ахуй болон экологийн алба, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв хамтран 2010-2011 онд Усны шувууд олноор бөөгнөрдөг газруудын мэдээллийг нэгтгэсэн ба мөн Монгол орны усны шувуудын Гахуунтан, Шунгууртан, Хотонтон, Өрвийтөн, Галуутаны багийн нийт 53 зүйлийн тархац, тоо толгойн мэдээллийг нэгдсэн системд оруулав.
Шийдвэр Х.19	Ус намгархаг газрууд ба голын сав газрын нэгдсэн менежмент: шинжлэх ухаан ба техникийн нэгдсэн удирдамж	<ul style="list-style-type: none"> • БОЯ, Японы олон улсын хамтын ажиллагааны ЖАИКА, Архангай аймаг хамтран Өгий нуурын Ус намгархаг газрын экосистемийг хамгаалах, зохистой ашиглах голын сав газрын менежментийн загвар төслийн хүрээнд Өгий нуур,

		түүний сав газрын экосистемийг хамгаалах зарчим, голын сав газрын менежментийн хөтөлбөрийг боловсруулав (Өгий нуурын экосистемийг хамгаалах төслийн тайлан, 2005 ба 2006.)
Шийдвэр Х.21	Шувууны халдварт өвчний тархалтанд хариу үзүүлэх удирдамж	<ul style="list-style-type: none"> • ШУА-ийн Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв, АНУ-ын Оклахомагийн их сургууль, АНУ-ын Геологийн судалгаа, НҮБ-ын ХХАХ, Солонгосын Үндэсний шинжлэх ухааны музей, Баруун бүсийн экологийн судалгааны төв хамтран Монгол Дагуурын Хайчийн цагаан, Хорин цагаан, Хөх нуурын Хошуу галуу (<i>Anser cygnoides</i>), Гангар хун (<i>Cygnus cygnus</i>)-д сансарын дамжуулагч, 60 гаруй Хошуу галуунд бөгж, хүзүүвч зүүж нүүдлийг судлахад Гангар хун Хятад, Өмнөд Солонгос, Хошуу галуу Хятадын Хөх мөрөнд очиж өвөлжиж байгааг тогтоожээ (Биологийн хүрээлэнгийн ЭШ-ний тайлан, 2006-2011; Nyambayar <i>et al.</i>, 2011; Newman <i>et al.</i>, 2009). Дээрх байгууллагууд хамтран Хорго-Тэрхийн Цагаан нуурын БЦГ-ын шувуудын бүрдэл, оршин амьдрах хэлбэрийг тодруулж, энд нийт 6,000 орчим Хээрийн галуу (<i>Anser indicus</i>) жил бүр гуужиж, Энэтхэгт очиж өвөлждөг болохыг 2008-2011 онд тогтоов (Биологийн хүрээлэнгийн ЭШ-ний тайлан, 2008-2011; Taekawa <i>et al.</i>, 2009; Prosser <i>et al.</i>, 2009). • Биологийн хүрээлэн, УМЭАЦТ лаборатори, 12 аймгийн мал эмнэлэг, байгаль орчны албаны хамгаалагч, мэргэжилтэн хамтран 2008-2011 онд Монгол орны 70 гаруй томоохон нуур, Рамсарын жагсаалтад багтсан нууруудыг хамруулан шувууны томуунд өртөх боломжтой шувуудын тоо толгой, тархац, түүний өвчний талаарх мэдээлэл цуглуулав

		<p>(Шувууны томууг тандах судалгааны тайлан, 2009-2011).</p> <ul style="list-style-type: none"> • НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагын Зэрлэг амьтны эрүүл ахуй болон экологийн алба, ШУА-ийн Биологийн хүрээлэн, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, АНУ-ын Геологийн судалгааны албаны Баруун бүсийн экологийн судалгааны төв, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв хамтран 2010-2011 онд шувууны томууны газар зүйн мэдээний системийг ашиглалтад оруулав (http://www.wsc.org.mn/birdflu.html).
Шийдвэр Х.22	Усны шувуудын хамгаалалд олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газарт Английн DISCOVERY экспедици судалгаа явуулж, түүнийхээ үр дүнгээр гарын авлага хэвлүүлсэнд уг нуур хийгээд тэнд амьдардаг шувуудын талаар дэлгэрэнгүй тусгагдсаны дээр Дэлхийн банкны санхүүжилтээр "Хөвсгөл нуурын биологийн төрөл зүйлийн хомсдол, цэвдгийн гэсэлтийн динамик" төсөл хэрэгжиж байна. • Биологийн хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв хамтран 2005, 2009-2011 онд Хар-Ус нуурын БЦГ, Айраг, Ачит нуурын усны шувуудын бүртгэл, Борцгор хотон (<i>Pelecanus crispus</i>)-ийн судалгааг гүйцэтгэж, тоо толгой нь сүүлийн жилүүдэд ихээр цөөрсөн болохыг тогтоов. Судалгааны үр дүнг BirdingAsia сэтгүүлд хэвлэв. Шувууны томууны тандан судалгааны явцад 2011 онд Айраг, Ачит, Буйр нуурын шувууны бүртгэл хийгдсэн ба мөн энэ нуураас гангар хун барьж хүзүүвч зүүх замаар нүүдлийг нь судалж байна. Хар-Ус нуурын гангар хун Хятадын төв хэсэгт очиж өвөлждөг.
Шийдвэр Х.26	Ус намгархаг газрууд ба газар доорх баялгийг	<ul style="list-style-type: none"> • Орхон голын сав газарт орших Өгий нуурын ус, намгархаг

	ашиглах	<p>газрын экосистемийг хамгаалах, тухайн бүс нутгийн байгалийн баялагийг цаашид зүй зохистой ашиглах аргачлалыг бий болгох зорилго бүхий “Ус, намгархаг газрын экосистемийг хамгаалах, зохистой ашиглах, голын сав газрын менежментийн загвар төсөл”-ийг 2005-2010 он хүртэлх хугацаанд Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага “ЖАИКА”-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн. Энэ төсөл нь Монгол орны Рамсарт бүртгэгдсэн болон бусад нуур, ус, намгархаг газрыг хамгаалахад загвар болох үр дүнтэй ажил болсон.</p>
--	---------	--



Шижир алтнаас үнэтэй цэнгэг ус бидний ирээдүй

Гэрэл зургийг С.Гомбобаатар©

ШИЙДВЭРҮҮДИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХАД ТОХИОЛДОЖ БУЙ БЭРХШЭЭЛ, СУРГАМЖ

- Конвенцийн Үндэсний зөвлөл Усны шувууд болон малчдын хувьд онцгой ач холбогдолтой, эмзэг ус намгархаг газрын жагсаалтыг гаргаж, дахин хянаж үзэх, Монгол орны ус намгархаг газар, түүнд амьдрах шувуудын одоогоор бий болоод байгаа анхдагч мэдээллийн сангийн материал болон бусад өгөгдлийг ашиглан үндэсний хэмжээний томоохон мэдээллийн сан үүсгэх, онлайн, интерактив болгоход төрийн байгууллагуудтай хамтран ажиллах нэн шаардлагатай.
- Томоохон нуур, голуудад Биологийн олон янз байдал, Ус намгархаг газар нутгийн индикатор болсон эргийн шувууд, ховор шувуудыг судлах, хамгаалах чиглэлээр урт хугацааны мониторингийн судалгааны цэгүүдийг байгуулан, Badley *et al.* (2005) нарын Олон улсын шувуу судлалын арга аргачлалыг ашиглан тогтмол ажиглалт явуулах замаар уур амьсгалын болон биологийн олон янз байдлын өөрчлөлтийг тандан судлах ажил хоцрогдож байна.
- Олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажил тухайлбал, тухайн газар нутагт хийсэн судалгааны ажлыг нэгтгэсэн гарын авлага, Тусгай хамгаалалттай газар нутгийн гарын авлага, тараах материал хангалтгүй байна.
- Энэ конвенцийн хүрээнд үндэсний бага хурлыг зохион байгуулах замаар мэдээллийн сангийн нэгдсэн баримтыг цуглуулах, судалгаа, хамгааллын ажлыг нэгтгэн дүгнэх, харилцан мэдээлэл, туршлага солилцох нь чухал.
- Рамсарын жагсаалтанд байгаа Өгий нуур, Нууруудын хөндийн нуурууд, Ачит нуур, түүний орчмын газар, Буйр нуур, Хурх, Хүйтэн голын хөндийн нуурууд улсын тусгай хамгаалалтад хамрагдаагүй байгаа учраас хамгаалалтын зохих арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ажил дутагдалтай байна.
- Архангай аймгийн Өгийнуур суманд хэрэгжсэн Ус, намгархаг газрын экосистемийг хамгаалах, зохистой ашиглах голын сав газрын менежментийн загвар төслийн туршлагыг Рамсарын гэрээнд бүртгэгдсэн бусад газруудад нэвтрүүлэх асуудлыг ирэх оноос төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй.
- МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Дорнын нүүдэлчид ХХК, ХААИС зэрэг төрийн ба төрийн бус байгууллагын эхлэн хэрэгжүүлж буй Нүүдлийн шувууны өдөр, Шувууны үндэсний өдөрлөг зэрэг үйл ажиллагааг БОАЖЯ болон санхүүжүүлэгч бусад байгууллагууд дэмжин оролцох нь уг конвенц болон усны нүүдлийн шувуудын судалгаа, хамгаалалд олон нийтийг татан оролцуулахад ихээхэн үүрэгтэйг анхаарах хэрэгтэй.
- Дээр дурдсан ажлууд нь хангалтай төвшинд зохион байгуулагдаагүй нь энэ конвенц санхүүжилт муутай, ажлын хэсгийн санаачилга муу, конвенцийн үндэсний мэдээллийн сан одоо хир байхгүйгээс шалтгаалж байгаа бөгөөд энэ нь мэдээ, баримтыг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, дүгнэлт гаргахад хүндрэл учруулж байлаа.

САНАЛ

- Усны шувууд болон малчдын хувьд ач холбогдолтой, Рамсарын жагсаалтанд буй ус намгархаг газрын жагсаалтыг дахин нягтлан үзэх, нэгдсэн арга аргачлал, судалгааны протокол боловсруулан жагсаалтанд бүртгэлтэй газар нутаг, түүнд амьдрах шувуудын талаарх нэгдсэн суурь мэдээллийн сангийн материал цуглуулах, шинэчлэх, мөн одоогоор цугларсан өгөгдлийг ашиглан үндэсний хэмжээний томоохон мэдээллийн сан үүсгэхэд Рамсарын Үндэсний зөвлөл, БОАЖЯ санхүүгийн хувьд дэмжин ажиллах нь зайлшгүй шаардлагатай.
- Томоохон нуур, голуудад Биологийн олон янз байдал, Ус намгархаг газар нутгийн индикатор болсон эргийн шувууд, ховор шувууд болон хоёр нутагтан зэргийн оролцоотой Биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн урт хугацааны мониторингийн судалгааны цэгүүдийг байгуулахыг бодлого болон санхүүгийн хувьд дэмжих нь нэгдэн орсон хэд хэдэн конвенцийн ажлыг хамтатган хийх давуу талтай.
- Олон нийтийн сургалт, сурталчилгааны ажил тухайлбал Рамсарын болон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн гарын авлагыг нэгдсэн бүтэц, агуулгатай хийхэд анхаарч бодлого болон санхүүгийн хувьд дэмжих нь чухал байна.
- Энэ конвенцийн хүрээнд үндэсний хэмжээний бага хурлыг зохион байгуулж, өмнө хийсэн ажлаа нэгтгэн дүгнэх, ирээдүйд хийх ажлаа алсыг харж төлөвлөх, улмаар Рамсарын үндэсний мэдээллийн сангийн нэгдсэн баримтыг цуглуулах, харилцан мэдээлэл, туршлага солилцох нь чухал бөгөөд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудыг энэ үйл ажиллагаанд татан оруулах нь зүйтэй.
- Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээс санаачилж буй нийтийг хамарсан ус намгархаг газар, усны шувуудыг судлах, хамгаалахыг сурталчилсан ажил (шувууны үндэсний өдөрлөг, нүүдлийн шувууны өдөр), Монгол орны усны шувууд, тэдгээрийг хамгаалах болон нийтийг хамарсан санаачилга (Туул голын хөндийн цэвэрлэх байгуууламжийг түшиглэн шувууны үндэсний парк байгуулах гэх мэт)-д конвенцийн Үндэсний зөвлөл, БОАЖЯ бодлого болон санхүүгийн хувьд дэмжин хамтран ажиллах нь чухал байна.

ТАЛАРХАЛ

Тайлан бичихэд үнэтэй зөвлөлгөө, санал өгсөн болон тайлангийн бүтцийн талаар тайлбар өгч тусалсан Дэлхийн байгаль хамгаалах сангийн ажилтан Б.Лхагвасүрэн, М.Хулан, БОАЖЯ-ны ГХАХ-ийн ажилтан Д.Ариунтуяа болон санхүү, зохион байгууллалтын зарим ажлыг дэмжин ажилласан НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хамт олон, БОАЖЯ-ны ГХАХ-ийн дарга Д.Батболд, Рамсарын Үндэсний зөвлөлийн гишүүд – П.Цогтсайхан, Н.Цэвээнмядаг, А.Намхай нарт болон тайлан бичихэд судалгаа, хамгааллын ажлын материалаа нэгтгэн өгсөн МУИС-ийн Шувуу судлалын лаборатори, ШУА-ийн Шувуу судлалын лаборатори, Монголын шувуу судлалын нийгэмлэг, Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв, Рамсарын жагсаалтад бүртгэлтэй газар нутгийн Байгаль орчны албаны хамт олонд гүн талархлаа илэрхийлж байна.

Тайлангийн техникийн зарим ажлыг гүйцэтгэж, гэрэл зургаар тусалсан Монголын шувуу судлалын нийгэмлэгийн ажилтнуудад баярлаж буйгаа илэрхийлье.

ИШ ТАТСАН БҮТЭЭЛ

Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тайлан 2006-2011. Улаанбаатар, Монгол улс.

Болд А. 2005. Бөөнцагаан нуур, түүний орчмын шувууд. *Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид 2: 23-32.*

Болдбаатар, Ш. Айраг нуур ба түүний орчим нутгийн шувууны тойм. *Биологийн хүрээлэнгийн ЭШ-ний бүтээл 27: 52-61.*

Гомбобаатар, С. ба Жаргалсайхан, П. 2011. *Хурх-Хүйтэний хөндийн шувууд.* Монголын шувуу судлалын нийгэмлэг, Монгол улсын их сургууль, Байгаль орчин, аялал жуулчлалын яам. Улаанбаатар. х.1-99.

Гомбобаатар, С., Д.Батмөнх, К.Озаки, Ёо. Шигета. 2011. *Баянхонгор аймгийн Бөөнцагаан нуур болон Өвөрхангай аймгийн Сангийн далай нуурын Гангар хун (Cugnus cugnus)-гийн нүүдлийн судалгаа.* Монгол улсын их сургуулийн Шувуу судлалын лаборатори, Монголын шувуу судлалын Нийгэмлэг, Японы шувуу судлалын Ямашина хүрээлэн, Дэлхийн Амьтдын эрүүл мэндийн байгууллага, Мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори. Улаанбаатар. Монгол улс. х.1-18.

Дэлхийн байгаль хамгаалах сан (2003). Дөргөний усан цахилгаан станцын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ. Улаанбаатар хот. х.1-206.

Мөнхтогтох, О. ба Шар, С. *Ондатрыг гаршуулах технологи.* Ховдын Их Сургууль, Ховд хот. х.1-78.

Өгий нуурын экосистемийг хамгаалах төслийн тайлан 2005. Өгий нуурын экосистем. Улаанбаатар 2005.

Өгий нуурын экосистемийг хамгаалах төслийн тайлан 2006. Өгий нуурын экосистем. Улаанбаатар 2007.

Цэвээнмядаг, Н. 2004. *Монгол Дагуурын дархан цаазат газар, түүний орчмын ус намгийн шувууд, Монгол Дагуурын ДЦГ-ын ховор шувууд.* Улаанбаатар, Монгол улс.

Цэвээнмядаг Н. Болд А. 2005. Өгий нуурын шувууд. *Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид 1: 33-41.*

Шувууны томууг тандах судалгааны тайлан 2009-2011. Улаанбаатар, 2012. (Англи, Монгол хэлээр)

Adiyasuren, Ts. 1998. National environmental management and wetland diversity conservation policy. *In the proceedings of the International Workshop on Wetland Conservation in Mongolia and North –East Asia.* Ulaanbaatar 16-19 Sep. 1997. p.1-11 (Англи хэлээр)

- Badley, J., Busuttil, S., Brookhouse J., Gombobaatar, S., Goroshko, O., Rowland, S., Thomas, M., Uuganbayar, Ch. 2005. *Important bird area surveys in Eastern Mongolia*. Ulaanbaatar. 73 pp. (In English and Mongolian)
- Ganbold, E. and Tsetsegmaa, D. 1998. Status report on wetland flora and priorities for conservation. *In the proceedings of the International Workshop on Wetland Conservation in Mongolia and North –East Asia*. Ulaanbaatar 16-19 Sep. 1997. p.38-45 (Англи хэлээр)
- Gombobaatar, S. 2004. Wintering water birds (Anseriformes) and their conservation. *2004 International Symposium on Migratory Birds*, GUNSAN, KOREA. p.187-201. (in English)
- Gombobaatar, S. and Monks, E.M. (compilers), Seidler, R., Sumiya, D., Tseveenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J. E. M., Boldbaatar, Sh., Uuganbayar, Ch. (editors). 2011. *Regional Red List Series Vol. 7. Birds*. Zoological Society of London, National University of Mongolia and Mongolian Ornithological Society. 1036 pp.
- Gombobaatar, S. (compiler), Brown, H.J., Sumiya, D., Tseveenmyadag, N., Boldbaatar, Sh., Baillie, J.E.M., Batbayar, G., Monks, E.M., Stubbe, M. (editors). 2011. *Summary Conservation Action Plan for Mongolian Birds. Regional Red List Series Vol. 8*. Zoological Society of London, Mongolian Ornithological Society and National University of Mongolia. 145 pp.
- Jeroen, R., Joop J., Jan W., Gombobaatar, S. 2005. The north-eastern Mongolian steppes: a stopover site of importance for Pacific Golden Plovers. *Wader Study Group* 108: 20.
- Newman, S.H., Iverson S.A et al. 2009. Migration of Whooper Swans and Outbreaks of Highly Pathogenic Avian Influenze H5N1 virus in Eastern Asia. *PLos ONE* 4 (5/e5729).
- Nyambayar, B., Takekawa J.Y et al. 2011. Migration strategies of Swan Geese *Anser cygnoides* from northeast Mongolia. *Wildfowl* 61:90-109.
- Taekawa, J.Y.,Shane R. et al. 2009. Geographic variation in Bar-headed Geese *Anser indicus*: connectivity of wintering areas and breeding grounds across a broad front. *Wildfowl* 59:100-123.
- Prosser, D.J., Takekawa J.Y et al. 2009. Satellite-marked waterfowl reveal migratory connection between H5N1 outbreak areas in China and Mongolia. *Ibis*. Doi: 10.1111/j.1474-919X.

Хавсралт 1.

Рамсарын конвенцийн хүрээнд Ус намгархаг газар, усны шувуудын чиглэлээр мэдээлэл, мэдээ, баримт солилцох, хамтран ажиллахад шаардлагатай хүмүүсийн нэр, хаяг

Рамсарын конвенцийн тухай мэдээллийг <http://www.ramsar.org> хаягаар хандаж авах боломжтой.

Рамсарын конвенцийн жагсаалтанд орсон Ус намгархаг газартай холбоо бүхий асуудал

Д. Батболд

Рамсарын конвенцийн Үндэсний зөвлөлийн дарга

БОАЖЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Нэгдсэн Үндэстний гудамж 5/2

Засгийн газрын II байр, Шуудангийн салбар-46

Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: 266171

Email: dbatbold@mne.gov.mn; gurkhem.batbold@gmail.com

<http://www.mne.mn>

Рамсарын конвенцийн Шинжлэх ухаан, техникийн хяналтын ажлын хэсэг

Доктор С.Гомбобаатар

Монгол улсын их сургууль, Биологи, биотехнологийн сургууль, Шувуу судлалын лаборатори

Улаанбаатар хот шуудангийн 46А салбар, хайрцаг 537.

Утас: 323970

Email: gomboo@num.edu.mn; info@mos.mn

<http://www.mos.mn>

Ус намгархаг газар, усны шувуудын нүүдэл шилжилт, мэдээллийн сан Ялангуяа бөгж тэмдэгтэй усны шувуудын талаарх бүртгэл, мэдээллийн сан

Доктор С.Гомбобаатар, магистр Ч.Ууганбаяр

Монголын шувуу бөгжлөлийн үндэсний төв

Монгол улсын их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль

Улаанбаатар хот шуудангийн 46А салбар, хайрцаг 537.

Утас: 323970

Email: mongolianbirds@mail.com; gomboo@num.edu.mn; uu_bb2001@yahoo.com

<http://www.mos.mn>

Доктор Н.Цэвээнмядаг, магистр Б.Нямбаяр

Шинжлэх ухааны академи, Биологийн хүрээлэн
Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв
Ерөнхий сайд А.Амарын гудамж 1
Улаанбаатар хот 210620
Монгол улс
Ш/х 20А/34
Утас: 262247
Email: tsevenmyadag@magicnet.mn; tsvmydg@yahoo.com; nyambayar@wscc.org

Энэхүү тайлангийн талаар

Доктор Б. Лхагвасүрэн
Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар
Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Амарын гудамж-4
Улаанбаатар хот шуудангийн 210620А салбар, Хайрцаг 115.
Утас: 311659, 319985
E-mail: lkhagvasuren@wwf.mn
<http://www.mongolia.panda.org>

Доктор С.Гомбобаатар
Монгол улсын их сургууль, Биологи, биотехнологийн сургууль,
Шувуу судлалын лаборатори
Улаанбаатар хот шуудангийн 46А салбар, хайрцаг 537.
Утас: 323970
Email: gomboo@num.edu.mn; info@mos.mn
<http://www.mos.mn>